

planetGOLD

Байгаль орчин болон нийгмийн хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагааны стандарт

2021 оны 2 дугаар сар

Агуулга

planetGOLD стандартын танилцуулга	3
Тайлбар	3
Эшлэл	3
Асуулт хариулт	3
Товчилсон үгийн жагсаалт	4
Танилцуулга	5
Зорилго	6
planetGOLD стандартын агуулга	7
planetGOLD стандартын үндэслэл	7
planetGOLD стандартын шалгуур үзүүлэлт ба Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч бичил уурхайчдын эрсдэл бууруулах системийн үнэлгээ.....	7
planetGOLD стандартын тусгай шаардлага/шалгуур үзүүлэлт.....	8
Шалгуур үзүүлэлт А : Мөнгөн усгүй хүдэр баяжуулах технологи ба химийн хорт бодис болон хаягдлын менежмент (цианид ба мөнгөн ус агуулсан хаягдал).....	9
Шалгуур үзүүлэлт Б : Нутгийн уугуул иргэдийн ашиг сонирхол болон амьдралыг хүндэтгэх	9
Шалгуур үзүүлэлт В : Байгаль орчныг хамгаалах.....	11
planetGOLD төслөөс бусад үйл ажиллагаа.....	12
Хэрэгжүүлэх үйл явц	12
Баримтжуулах ба баталгаажуулалт	14
Ашигласан материал	15
ХАВСРАЛТУУД	17
Хавсралт I: Ажил хариуцах хүн томилох процесс	17
Хавсралт II: planetGOLD стандартыг хэрэгжүүлэх үйл явц	19
Хавсралт III: Баримтжуулах үйл явц	21
Хавсралт IV: Нэр томъёоны тайлбар	22

planetGOLD стандартын танилцуулга

Энэхүү гарын авлага нь planetGOLD хөтөлбөрт хамрагдаж буй алтны бичил уурхайчдын үйл ажиллагааг зохицуулах тодорхой шалгуурыг тодорхойлсон болно. Эдгээр шалгуурыг дагаж мөрдсөнөөр хөтөлбөрийн ашиг хүртэгсэд Даян дэлхийн байгаль орчны санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдээс шаарддаг байгаль орчин, нийгмийн хамгааллын шаардлагыг ханган байна. Энэ бичиг баримт нь байнга шинэчлэгдэж сайжирч байх ёстой бөгөөд planetGOLD хөтөлбөр төсөл хэрэгжүүлж буй туршлага дээрээ үндэслэн засварлах эрхтэй. Стандартын албан ёсны хэл нь англи хэл бөгөөд бусад бүх хувилбарыг орлох болно. Дэлгэрэнгүй мэдээллийг planetGOLD.org-оос үзнэ үү.

Тайлбар

planetGOLD стандарт нь Хариуцлагатай уул уурхайн холбооноос санаачлан гаргасан албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч бичил уурхайчдын эрсдэл бууруулах системийн үнэлгээ код буюу CRAFT-ын нэгэн хэсэг юм.

Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч бичил уурхайчдын эрсдэл бууруулах системийн үнэлгээ буюу CRAFT кодыг “Creative Commons Attribution-ShareAlike 4.0 International” лицензийн (<https://creativecommons.org/licenses/by-sa/4.0/>) дагуу гаргав.¹

CC-BY-SA-ийн ShareAlike нөхцлийг хангахын тулд planetGOLD стандартыг CC-BY-SA лицензийн дагуу нийтэлсэн бөгөөд энэ нь нээлттэй эх сурвалж юм.



Эшлэл

planetGOLD хөтөлбөр. 2021. planetGOLD стандарт нь CRAFT 2.0-р (2020 оны 10-р сард ХУУХ-ноос гаргасан www.craftmines.org) хувилбарыг ашигласан CRAFT код юм.

Санал хүсэлт

Бид planetGOLD стандартын талаарх санал хүсэлт хүлээн авна. Бидэнтэй www.planetgold.org-оор дамжуулан холбогдоно уу.

¹ Эдгээр хувилбарууд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд албан ёсны хэл болох Англи хувилбарыг сонгоно уу. Хувилбар 2.0. (2020 оны CRAFT 2.0)

Товчилсон үгийн жагсаалт

АБУ	Алтны бичил уурхай
ХУУХ	Хариуцлагатай Уул Уурхайн Холбоо
БУ	Бичил уурхай
CRAFT	Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч бичил уурхайчдын эрсдэл бууруулах системийн үнэлгээ
МШУ	Магадлан шинжилгээний удирдамж
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ДДБОС	Даян дэлхийн байгаль орчны сан
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ЛҮМБХ	Лондонгийн үнэт металлын биржийн холбоо
БУБ	Бичил уурхайн байгууллага
ХБШ	Хамгийн бага шаардлага (ДДБОС-ийн стандартад хэрэглэсэн)
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
НУББОХ	Нэгдсэн үндэсний байгууллагын байгаль орчны хөтөлбөр
НУБАҮХБ	Нэгдсэн үндэсний байгууллагын аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага

Танилцуулга

Бичил уурхайн үйл ажиллагаа нь дэлхийн хэмжээнд хөгжиж байгаа 80 гаруй орны 10-20 сая иргэдийн ажил хөдөлмөрийн эх үүсвэр болж байна. Ихэнхдээ албан бус үйл ажиллагаа явуулдаг боловч дэлхийн алтны зах зээлийн 20 орчим хувийг нийлүүлдэг энэ салбараас 100 гаруй сая хүн амьжиргаагаа залгуулж байна.² Гэвч алтны бичил уурхайн үйл ажиллагаа нь мөнгөн усны бохирдлын гол эх үүсвэр болж байна. Дэлхийн мөнгөн усны үнэлгээнд тусгаснаар нийт мөнгөн усны бохирдлын 38 хувь нь алтны бичил уурхайгаас үүсдэг гэжээ. Бүс нутгийн хувьд авч үзвэл “нийт бохирдлын 70-80 хувь нь Өмнөд Америк болон Африкийн Хагас Цөлийн бүс нутгаас үүсэж байна” хэмээн тусгажээ (НҮББОХ, 2019).

Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүсэж байгаа ихээхэн хэмжээний мөнгөн усны бохирдлын нөлөөг харгалзан үзэж Мөнгөн Усны Тухай Миниматагийн Конвенцид (НҮББОХ, 2013) алтны бичил уурхайн мөнгөн усны асуудлыг тусгайд (7 дугаар зүйл) нь хэлэлцэж баталсан. Конвенцоос бичил уурхайн үйл ажиллагаа бүхий орнуудад хандаж мөнгөн усны хэрэглээг багасгах, зайлшгүй зарим тохиолдолд ашиглахаас бусад мөнгөн усны өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн дэх хэрэглээг хязгаарлах, уул уурхайн болон баяжуулах үйлдвэрийн процесст ашиглагддаг мөнгөн ус, түүний нэгдлүүдийг багасгах, улмаар ялгарлыг бууруулах Үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг шаардсан (НҮББОХ, 2013).

Үндэсний хөтөлбөрт мөнгөн устай холбоотой буруу практикийг зогсоох, хэрэглээг багасгах, мөнгөн усны хордлогод өртөлтийг бууруулах болон бусад стратеги төлөвлөгөө багтсан. Үүнийг хэрэгжүүлэхэд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, хүмүүсийн техникийн болон бизнесийн ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах гэх мэтчилэн хөрөнгө мөнгө шаардагдсан ажил зохион байгуулах шаардлагатай юм. Одоогийн байдлаар алтны бичил уурхайн салбар энэ шилжилтийг хийхэд хууль эрхзүйн, нийгмийн болон бусад саад бэрхшээлтэй тулгарч байна.

Даян дэлхийн байгаль орчны сангийн санхүүжилттэй planetGOLD хөтөлбөр алтны бичил уурхайн байгууллагуудын хөрөнгө санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэх, албан ёсны зах зээлд оролцох, мөнгөн усгүй технологи нэвтрүүлэх болон үйл ажиллагаагаа албажуулахад нь дэмжлэг үзүүлэх замаар эдгээр саад бэрхшээлийг бууруулах чиглэлээр ажиллаж байна. Бичил уурхайн байгууллага нь алт олборлохдоо байгаль орчин болон нийгмийн хариуцлагын холбогдох стандартыг дагаж мөрдөн гүйцэтгэснээр хөрөнгө, санхүүжилт татах, албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд оролцох боломжтой болдог. Энэхүү удирдамж нь planetGOLD хөтөлбөрт хамрагдагсад дээрх шаардлагыг хангаж ажиллахад нь хувь нэмэр оруулах зорилготой юм.

² <https://www.iisd.org/sites/default/files/publications/igf-asm-global-trends.pdf>

Зорилго

Энэхүү удирдамжид planetGOLD хөтөлбөрт хамрагдагч алтны бичил уурхайн байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэх тусгай шалгуурууд багтсан. planetGOLD хөтөлбөрт хамрагдаж байгаа бичил уурхайчид энэхүү удирдамжийн шалгууруудыг хангаснаар бичил уурхайн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, сааруулах, боломжтой үед арилгах зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлдэг болно. Мөн түүнчлэн эрсдэлийг бууруулахад шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр ДДБОС-ын санхүүжилттэй төсөл хөтөлбөрт тавигддаг байгаль орчин, нийгмийн хариуцлагын шаардлагуудыг хангаж өөрсдийн үйл ажиллагаандаа хөрөнгө санхүүжилт татах, олборлосон алтаа албан ёсны зах зээлд худалдан борлуулах боломжоо нэмэгдүүлнэ.

planetGOLD стандартын агуулга

planetGOLD стандартын агуулга

Байгаль орчин, нийгмийн хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагааны planetGOLD стандартыг (цаашид planetGOLD-ын стандарт гэх) боловсруулахын өмнө одоогоор хэрэгжиж байгаа хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний тухай стандартууд, ДДБОС болон бусад олон улсын хөгжлийн олон санхүүжүүлэгч байгууллагуудын холбогдох бодлогын баримт бичгүүдийг³ судалж үзсэн болно. Түүнчлэн Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц, ДДБОС-ын Байгаль орчин, нийгмийн хариуцлагын дүрэм, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (ЭЗХАХБ)⁴ магадлан шинжилгээний удирдамж (МШУ) болон Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч бичил уурхайчдын эрсдэл бууруулах системийн үнэлгээ буюу CRAFT зэрэгт тавигдсан шаардлагад онцгойлон анхаарал хандууллаа.

CRAFT-ыг анх бичил уурхайчид болон тэдний олборлосон ашигт малтмалыг худалдан авагчдад ЭЗХАХБ-ын МШУ-ийн шаардлагад нийцүүлж ажиллахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулсан. Үүнээс хойш CRAFT-ыг ашигт малтмалын хариуцлагатай үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үнэлэх чиглэлээр олон талууд нээлттэйгээр ашиглаж байна. Энэхүү үнэлгээг салбар дундын 2 зөвлөлийг (Стандартын зөвлөл ба Зөвлөлийн бүлэг)⁵ оролцуулан оролцооны аргаар боловсруулах явцад олон дахин турших, тохируулах ажлыг зэрэг гүйцэтгэсэн болно. Үүний үр дүнд энэхүү үнэлгээ нь ЭЗХАХБ-ын МШУ, Лондонгийн үнэт металлын биржийн Хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээ хөтөлбөрийн Хариуцлагатай алт удирдамж болон Хариуцлагатай гоёл чимэглэлийн зөвлөлийн Дүрэм журмын ихэнх шаардлагатай нийцсэн болно.

planetGOLD стандарт нь CRAFT-тай нийцэж байгаа бөгөөд энэ стандартын үнэлгээг хийхэд тохируулан ашиглаж болно. CRAFT-тэй нийцсэнээр planetGOLD стандартыг хангаж байгаа бичил уурхайн байгууллагууд нь бусад гол стандартуудын шаардлагыг хангах боломжтой юм.⁶ CRAFT-тэй нийцүүлэхийн дээр энэхүү стандарт нь planetGOLD хөтөлбөрийн гурван тусгай шалгуур үзүүлэлтийг нэмж багтаасан. CRAFT-тэй нийцүүлсэн элементүүд болон planetGOLD хөтөлбөрийн тусгай шалгуур үзүүлэлтийг доор тодорхойлов.

³ Энэхүү удирдамжийг одоо ашиглаж байгаа дараах хариуцлагатай эх үүсвэрийн стандартын хөтөлбөрүүдийг харьцуулан судалж боловсруулсан болно. Үүнд: Хариуцлагатай уул уурхайн холбоо (ARM), Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч бичил уурхайчдын эрсдэл бууруулах системийн үнэлгээ (CRAFT), Шударга олборлолт, Даян дэлхийн байгаль орчны сан (GEF), Лондонгийн үнэт металлын биржийн холбоо (LBMA), Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын магадлан шинжилгээний удирдамж, Минаматагийн Конвенц, Хариуцлагатай гоёл чимэглэлийн зөвлөл, НҮББОХ, НҮБҮХБ.

⁴ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын магадлан шинжилгээний удирдамж болон бусад хэрэглэгдэхүүнүүд нийлүүлэлтийн сүлжээнд оролцогсдыг эрсдэлд суурилсан магадлан шинжилгээ болон ил тод системийг хэрэгжүүлэхийг ойлгон дагаж мөрдөх процесс бүрдүүлэхийг шаарддаг (CRAFT 2.0, 2020).

⁵ Энэ 2 бүлэг нь бичил уурхайчид, алт цэвэршүүлэгчид, үйлдвэрлэгчдийн холбоо, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг бичил уурхайчидтай шууд харьцдаг талуудаас бүрдсэн бөгөөд бие даасан экспертүүд энэхүү үнэлгээний системийг хөгжүүлэх, цар хүрээг тодорхойлоход дэмжлэг үзүүлж ажилласан.

⁶ CRAFT нь үүнийг ашиглаж, шаардлагыг хангаж, нийцэж ажиллах замаар бүрдүүлсэн нийлүүлэлтийн сүлжээний систем юм. CRAFT-ийг нийлүүлэлтийн сүлжээнд оролцогсод ЭЗХАХБ-ын МШУ болон БУ-гаар олборлосон ашигт малтмалын үйлдвэрлэгчдийн шаардлагыг хангаж, хамтран ажиллах зорилгоор хэрэгжүүлдэг. (CRAFT 2.0-ийн Vol. 1-ийг үзнэ үү).

planetGOLD шалгуур үзүүлэлт ба CRAFT code

planetGOLD шалгуур үзүүлэлт нь [CRAFT Code 1-4 дүгээр Модулийг](#) тусгасан. Үүнд:

Модуль 1-д тусгаснаар planetGOLD стандартын дагуу бичил уурхайн байгууллага үйл ажиллагааныхаа талаарх мэдээлэл өгнө. Үүнд бичил уурхайн байгууллагын нэр, байгууллагын доторх нэгжийн хэлбэр, газарзүйн байршил байхаас гадна доорх мэдэгдлүүд орно. Үүнд:

- ▶ planetGOLD стандартын шаардлагыг биелүүлэхээ бичгээр илэрхийлсэн байх;
- ▶ Мөнгөн усны тухай Миниматагийн конвенцын шаардлагын дагуу ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаанаас гарах мөнгөн усны бохирдол болон өртөлтийг мөнгөн усгүй технологи нэвтрүүлэх замаар бууруулах чиглэлээр ажиллана гэдгээ бичгээр⁷ илэрхийлсэн байх;
- ▶ planetGOLD стандартын хэрэгжилтийг хариуцаж ажиллах хүнийг томилж холбогдох мэдээллийг өгсөн байна.

Модуль 2-д бичил уурхайн байгууллагын **албан ёсны** байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд багтсан. Бичил уурхайн салбарын албан ёсны байдлыг тогтооход хүндрэлтэй байдаг талыг харгалзан үзэж CRAFT-ын Модуль 2-т тухайн бичил уурхайн байгууллагын үйл ажиллагааны статусыг тодорхойлох 4 төрлийн **“улс орны нөхцөл байдлын кейс”** оруулсан. Эдгээр нь бичил уурхайн байгууллагыг албан ёсоор үйл ажиллагаа явуулдаг гэдгээ харуулахад нь чиглүүлэх зорилготой юм.⁸

Модуль 3-д Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын магадлан шинжилгээний удирдамжийн Хавсралт II-ын дагуу ашигт малтмал худалдан авагчид бичил уурхайн байгууллагатай хамтын ажиллагаагаа нэн даруй зогсоох, эсвэл нэн даруй түдгэлзүүлэх шаардлагатай эрсдэлүүдийг тусгасан байна. **Модуль 4-д** Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын магадлан шинжилгээний удирдамжийн Хавсралт II-ын дагуу тодорхой эрсдэлүүдийг бууруулах арга хэмжээ амжилтгүй болсон тохиолдолд ашигт малтмал худалдан авагчид бичил уурхайн байгууллагатай хамтын ажиллагаагаа нэн даруй зогсоох, эсвэл нэн даруй түдгэлзүүлэх нөхцөлийг тусгасан байна (CRAFT 2.0, 2020).

Модуль 3 болон 4-т эдгээр өндөр эрсдэлүүдийн талаарх дэлгэрэнгүй тодорхойлолтыг харуулав. ⁹

⁷ Хавсралт С - Мөнгөн Усны Тухай Миниматагийн Конвенц (НҮББОХ, 2013)

⁸ Vol. 2A, Модуль 2 ба Vol. 4, Хэсэг 2.2 үзэх (CRAFT 2.0, 2020)

⁹ Vol. 2A Модуль 3 ба Модуль 4 (CRAFT 2.0, 2020) , Vol 4. Хэсэг 2.3 ба Хэсэг 2.4 (CRAFT 2.0,2020)

МОДУЛЬ 3: “Хавсралт II- т тусгасан эрсдэл” – доор дурдсан асуудал гарсан тохиолдолд хамтын ажиллагаагаа нэн даруй таслан зогсоох шаардлагатай.¹⁰ Үүнд:	МОДУЛЬ 4: “Хавсралт II-т тусгасан эрсдэл” –доор дурдсан асуудлыг зохицуулах төлөвлөгөө амжилтгүй болсон тохиолдолд хамтын ажиллагаагаа нэн даруй таслан зогсоох шаардлагатай.¹¹ Үүнд:
<ul style="list-style-type: none"> • Шууд ба шууд бус ямар нэгэн байдлаар хүнийг албан хүчээр ажиллуулсан, хүүхдийн хөдөлмөрийг мөлжих;¹² 	<ul style="list-style-type: none"> • Бичил уурхайн байгууллагын үйл ажиллагааг хууль бусаар хянадаг хүчинд шууд ба шууд бус ямар нэгэн байдлаар дэмжлэг үзүүлсэн байх; • Хүний эрх, аюулгүй байдлыг хууль журмын дагуу хамгаалдаг засгийн газрын болон хувийн хамгаалалтын хүчинтэй хамтран ажилладаггүй бол;
<ul style="list-style-type: none"> • Хүний эрхийн зөрчилтэй холбоотой ямар нэгэн үйл ажиллагаа хийсэн, оролцсон;¹³ • Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрт ойр байх, байрласан байх; • Зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэг бус үйлдэл, болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт холбогдсон бол;¹⁴ • Хууль бус хүчний хяналт доор байдаг, засгийн газрын бус зэвсэгт хүчин, хамгаалалтын хүчинд хууль бусаар татвар, мөнгө төлдөг бол.¹⁵ 	<ul style="list-style-type: none"> • Хүний эрхийн ноцтой зөрчил үүсгэж байсан хувь хүн болон бүлэгтэй холбоотой бол; • Хамгаалалтын хүчин болон Засгийн газарт төлсөн төлбөрийг худал мэдүүлсэн; • Ашигт малтмал олборлохтой холбоотой үйл ажиллагаанд ноогдсон татвар, хураамж болон нөөц ашигласны төлбөр төлсөн талаарх баримт нотолгоо байхгүй байх; • Авилга, хээл хахууль санал болгосон, амласан, эсвэл шаардсан бол; • Мөнгө угаах үйл явцад хувь нэмэр оруулсан бол.

[Крафт бичиг баримтнаас](#) уг аюулын талаар нарийвчилсан танилцуулгыг харж болно.

¹⁰ Минаматагийн конвенцын 7-р хэсэг болон Хавсралт С-г үзнэ үү (НҮББОХ, 2013)

¹¹ Минаматагийн конвенцын 7-р хэсэг болон Хавсралт С-г үзнэ үү (НҮББОХ, 2013)

¹² MS5 үзэх: Уугуул иргэд (ДДБОС, 2018)

¹³ MS3-аас үзэх: Биологийн төрөл зүйлийг хамгаалах ба амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент (ДДБОС, 2018)

¹⁴ Vol. 2B үзэх, Модуль 5, Хэсэг М.5/1.3.11/SR.1-4 (CRAFT 2.0, 2020)

¹⁵ Vol 2A үзэх, Модуль 5 (CRAFT 2.0, 2020)

planetGOLD-ын тусгай шаардлага/ шалгуур үзүүлэлт

Мөнгөн усны тухай Миниматагийн конвенцыг хэрэгжүүлэхэд нь талуудад дэмжлэг үзүүлдэг Даян дэлхийн байгаль орчны сангийн санхүүжилттэй хөтөлбөрийн хувьд planetGOLD хөтөлбөрт хамрагддаг төслүүд конвенцын шаардлагыг биелүүлж ажиллахаас гадна Даян дэлхийн байгаль орчны сангийн Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлогыг мөрдөж ажилладаг. Иймээс planetGOLD хөтөлбөрт **хамрагддаг бичил уурхайн байгууллагууд** CRAFT-ын Модуль 1-4-ийн шаардлагыг хангаж ажиллахаас гадна planetGOLD хөтөлбөрийн доорх 3 нэмэлт шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах шаардлагатай.¹⁶

- ▶ Мөнгөн усны тухай Миниматагийн конвенцын зорилтын дагуу ашигт Малтмал олборлох үйл ажиллагаанд мөнгөн усны хэрэглээг халах болон **мөнгөн уснаас бохирдсон хаягдлыг зохих журмын дагуу саармагжуулах, Хавсралт С;**¹⁷
- ▶ Даян дэлхийн байгаль орчны сангийн Байгаль орчин, нийгмийн хариуцлагын шаардлагын дагуу **нутгийн [уугуул иргэдийн эрхийг хүндэтгэх, хамгаалах;](#)**¹⁸
- ▶ Даян дэлхийн байгаль орчны сангийн шаардлагын дагуу байгаль орчныг хамгаалах нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлэх замаар биологийн төрөл зүйлд учруулах нөлөөг багасгах, **ялангуяа ховордсон амьтан ургамал, тэдний амьдрах орчинг хамгаалах;**¹⁹

Эдгээр нэмэлт шаардлагуудыг хангах нь CRAFT-ын [Модуль 5](#) буюу Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын магадлан шинжилгээний удирдамжид тусгайлан тусгаагүй өндөр эрсдэлтэй уялдаатай бөгөөд Хавсралт II-т тусгаагүй эрсдэл²⁰ гэж нэрлэгдсэн. planetGOLD-ын эдгээр 3 тусгай шаардлага нь CRAFT-ын Модуль 5-ын дараах заалтуудтай нийцэж байгаа юм.

Үүнд: (1) Мөнгөн усны хэрэглээ ба үйлдвэрлэл,²¹ (2) Нутгийн оршин суугчид болон уугуул иргэдийн эрх ашиг,²² ба (3) Газар ашиглалт ба биологийн төрөл зүйл.²³

¹⁶ Хавсралт С үзэх, догол мөр 1 (b) (iv) (Минаматагийн Конвенц); Vol. 2B үзэх, Модуль 5, Хэсэг M.5/1.3.11/SR.4 (CRAFT 2.0,2020)

¹⁷ https://www.un.org/esa/socdev/unpfii/documents/UNDG_guidelines_EN.pdf

¹⁸ MS5: догол мөр 11, a-i (ДДБОС, 2018)

¹⁹ Уугуул иргэдийн эрхийн тухай Нэгдсэн Үндэсний Байгууллагын тунхаглал. Доорх холбоосоор орж үзнэ үү: www.un.org/esa/socdev/unpfii/documents/DRIPS_en.pdf

²⁰ MS5: par.10, a-c (GEF, 2018)

²¹ Хүдрийн хаягдал, химийн бодис болон шатахууны үлдэгдлээс бусад ус ашиглагчдад учруулж байгаа нөлөөг үнэлсэн байна. Өндөр эрсдэл бүхий ашигласан усны бохирдлыг хянадаг байх. Бохирдол бууруулах техникийн шинэчлэлийг дэвшүүлж хэрэгжүүлсэн байх. Усны чанар бусад ус хэрэглэгчдийн эрүүл мэнд болон экосистемийн ноцтой эрсдэлийн шалтгаан болохгүй байх (Vol 4, Sec. 2.5.4, M.5/4.2.2/R.1 үзэх, CRAFT 2.0, 2020)

²² Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам: 3.1.5 Бичил уурхайн эрхлэгч этгээд нь байгаль орчныг хамгаалж, гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх үүрэгтэй;

²³ Vol. 4, Sec. 2.5.4, M.5/4.2.2/R.1, CRAFT 2.0, 2020; MS7 (GEF, 2018)

Шалгуур үзүүлэлт А : Мөнгөн усгүй хүдэр баяжуулах технологи болон химийн хорт бодис, хаягдлын менежмент (цианид ба мөнгөн ус агуулсан хаягдал) Энэ шалгуур үзүүлэлтийн дагуу бүх бичил уурхайн байгууллагууд мөнгөн усны хэрэглээгээ халах ба Мөнгөн усны тухай Минаматагийн Конвенцын (НҮББОХ 2013) Хавсралт С-ын дагуу өмнөх баяжуулалтын шатанд мөнгөн усны амальгам хийсэн бөгөөд мөнгөн усыг нь гүйцэд сайн ялгаагүй байж болзошгүй хаягдлыг цианидаар уусган дахин баяжуулах хамгийн муу үйл явцыг халах шаардлагатай.

байгууллагууд мөнгөн усны хэрэглээгээ халах ба Мөнгөн усны тухай Минаматагийн Конвенцын (НҮББОХ 2013) Хавсралт С-ын дагуу өмнөх баяжуулалтын шатанд мөнгөн усны амальгам хийсэн бөгөөд мөнгөн усыг нь гүйцэд сайн ялгаагүй байж болзошгүй хаягдлыг цианидаар уусган дахин баяжуулах хамгийн муу үйл явцыг халах шаардлагатай.

Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хэлбэр
A1. Байгууламжууд мөнгөн уснаас ангид байна.	Хүдэр баяжуулах цехүүдэд мөнгөн ус ашигласан тухай ямар нэгэн ул мөр байхгүй байх.
A2. Мөнгөн усаар өмнө нь амальгам хийсэн бөгөөд урьдчилан мөнгөн усыг нь бүрэн гүйцэд ялгаагүй баяжмал, хүдэр болон баяжмалын хаягдлыг цианидаар уусган баяжуулаагүй байна. ²⁴	Боловсруулах байгууламжид цианид ашигласан, мөнгөн усаар бохирдсон хаягдлыг бусад боловсруулагчдад худалдсан гэх баримт байхгүй; болон боловсруулах байгууламжууд нь хаягдлыг цаашид боловсруулах, худалдах, хаягдлыг зайлуулахаас өмнө мөнгөн усыг цэвэршүүлсэн (мөн мөнгөн усны байгаль орчинд ээлтэй менежмент) нотлох баримтаар хангадаг.

Шалгуур үзүүлэлт Б : Нутгийн уугуул иргэдийн ашиг сонирхол болон амьдралыг хүндэтгэх: Бичил уурхайн байгууллага хүний эрхийн тухай олон улсын хууль эрх зүйн баримт бичигт тусгасны дагуу уул уурхайн үйл ажиллагаанаас хамгийн их сөрөг нөлөө амсаж байж болзошгүй нутгийн уугуул иргэдийн болон хамт олны эрх ашиг, соёл, соёлын өв, уламжлалт газар, дүр зураг болон амьдралыг хүндэтгэн үздэгээ илэрхийлж баталгаажуулна.^{25,26}

Бичил уурхайн байгууллага хүний эрхийн тухай олон улсын хууль эрх зүйн баримт бичигт тусгасны дагуу уул уурхайн үйл ажиллагаанаас хамгийн их сөрөг нөлөө амсаж байж болзошгүй нутгийн уугуул иргэдийн болон хамт олны эрх ашиг, соёл, соёлын өв, уламжлалт газар, дүр зураг болон амьдралыг хүндэтгэн үздэгээ илэрхийлж баталгаажуулна.^{25,26}

Тайлбар: planetGOLD-ын доорх шалгуурууд нь хэрэгжүүлэх тодорхой арга хэрэгсэл, түүний дотор үнэгүй, урьдчилсан болон мэдээлэлтэй зөвшөөрөл авах зэрэг үндэсний хууль тогтоомж, нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байж болохыг хүлээн зөвшөөрдөг.

²⁴ Энэ CRAFT болон ЭЗХАХБ МШУ Хавсралт II-д тусгасан шаардлага юм.

²⁵ Тайлангийн загварыг авч болно.

²⁶ Бичил уурхайн байгууллага үйлдвэрлэлийн түвшний асуудлыг өөрсдөө нотолж баталгаажуулж болох ба харин нийлүүлэлтийн сүлжээний түвшний асуудлыг хоёрдогч этгээдээр баталгаажуулна. (CRAFT, 2018).

Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хэлбэр
<p>Б1. Бичил уурхайн байгууллага нь нутгийн уугуул иргэдийн эрх ашиг, газар дэвсгэр, байгалийн баялаг болон соёлын өвийг хүндэтгэн үзэх тухай бодлогын баримт бичиг боловсруулж олон нийтэд нээлттэй байлгана.²⁷</p>	<p>Бичил уурхайн байгууллага нь нутгийн уугуул иргэдийн эрх ашиг, газар дэвсгэр, байгалийн баялаг болон соёлын өвийг хүндэтгэн үзэх тухай бодлогын баримт бичиг боловсруулж олон нийтэд нээлттэй байлгах ба байгууллагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар өртөж байгаа нутгийн иргэд энэ талаар мэдээлэлтэй байхыг баталгаажуулна.</p>
<p>Б.2 БУБ нь уул уурхайн нийгэмлэг болон үйл ажиллагаа шууд болон шууд бусаар нөлөөлж болзошгүй уугуул иргэд байгаа эсэхийг тодорхойлох ёстой.</p>	<p>Уул уурхайн байгууллага нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Уул уурхайн нөлөөнд өртөж болзошгүй уугуул иргэдийг тодорхойлоход туслах зорилгоор зөвлөлдсөн хүмүүс болон ашигласан бусад аргуудын тодорхойлолтыг өгөх; 2. Ийм нөлөөнд өртсөн уугуул иргэдийн төлөөлөл байгууллагуудыг үйл ажиллагаандаа татан оролцуулах төлөвлөгөөг бичгээр гаргаж өгөх ёстой.
<p>Уул уурхайн байгууллага нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Уул уурхайн үйл ажиллагаанаас гарч болзошгүй эерэг болон сөрөг нөлөөг тодорхойлохын тулд нөлөөлөлд өртсөн уугуул иргэдийн соёл иргэншилд тохирсон арга барилаар сурталчилгаа явуулах хэрэгтэй. Эдгээр нөлөө нь дараах байдлаар илэрч болно. <ul style="list-style-type: none"> а) Уламжлалт эзэмшлийн газар байх, үүнийг ямар нэгэн байдлаар ашиглах, ийм газарт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр болон ашигт малтмалын үйлдвэрлэлийн ач холбогдол зэргээс шалтгаалж нутгийн уугуул иргэдийн газар ашиглахыг хязгаарлах болон газар нутгаа алдахад хүргэх; б) Тухайн бус нутгийг уламжлалт аргаар эзэмшдэг болон үүн дээр үйл ажиллагаа явуулж ашиглаж байгаагаас шалтгаалж газар нутаг, байгалийн баялгаас нь шилжүүлэн суурьшуулах; с) Олборлолт хийх зорилгоор соёлын өвийг ашиглах, сөрөг нөлөө учруулах. ²⁸ 2. Уугуул иргэдтэй хамтран ажиллахдаа: <ul style="list-style-type: none"> а) Тэднээс зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зуруулж авч, тодорхойлу нөлөөг бууруулах; ЭСВЭЛ б) Хэрэв тэд хүсэлтийг хүлээн авахгүй, нэмэлт мэдээлэл, тодруулга авах хүртэл хүсэлтийг хойшлуулахаар шийдсэн бол уугуул иргэдийн шийдвэрийг хүндэтгэнэ. 	<p>Бичил уурхайн байгууллага нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Уугуул иргэдийн бүрэн эрхт төлөөлөгчийн байгууллагатай хамтран ажиллах баримт бичгийг бүрдүүлж, төслийн талаар танилцуулах, хэлэлцүүлэх болон бусад хэлбэрээр зөвлөлдөх, бүрэн эрхт төлөөлөгчийн байгууллагаас тавьсан асуултад хариулах; 2. Учирч болох нөлөөг тодорхойлоход ашигласан аргын тайлбарыг өгөх; 3. Аливаа эерэг болон сөрөг нөлөөллийн талаар тайлан гаргах; болон 4. Сөрөг нөлөөллийг бууруулах нотлох баримтыг гаргаж өгөх ёстой.

²⁷ Ашигт малтмал олборлох, тээвэрлэх болон худалдаалах үйл ажиллагаатай холбоотой ноцтой дарамт шахалт, хүчирхийллийн тухай (ЭЗХАХБ 2016b, Хавсралт II, догол мөр 1)

²⁸ Засгийн газрын бус зэвсэгт бүлэглэл, хамгаалалтын хүчнийг тодорхойлоход компаниуд НҮБ-ийн Хамгаалах албаны зөвлөлийн журамыг барина (ЭЗХАХБ 2016b, Хавсралт II, догол мөр 3)

Шалгуур үзүүлэлт В: Байгаль орчныг хамгаалах

Бичил уурхайн байгууллага олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаандаа байгаль орчны хариуцлагатай, түүнийг хамгаалах, доройтлоос урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээхэд чиглэсэн арга технологи хэрэглэнэ. Хариуцлагатай бичил уурхайн байгууллагууд өөрийн улсын байгаль орчныг нөхөн сэргээх, олборлолтын үйл ажиллагаанаас үүссэн зайлшгүй сөрөг нөлөөллийг бууруулах, биологийн төрөл зүйлийг хамгаалах байгууллагын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх гэх мэт байгаль орчны тухай хууль эрхзүйн орчны хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байна.

Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хэлбэр
<p>В1. Бичил уурхайн байгууллага байгаль орчныг хамгаалах талаарх бүх хууль эрхзүйн орчин, шаардлагыг судалж дагаж мөрдөх бөгөөд байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, онцгой ач холбогдол бүхий хамгаалагдсан газар нутагт үйл ажиллагаа явуулахаас зайлсхийх.</p>	<p>Бичил уурхайн байгууллага дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тухайн улсын хууль журмын дагуу олборлолтын тусгай эрх авах шаардлагатай бол лицензтэй байх, эсвэл тухайн газрыг бичил уурхайн зориулалтаар ашиглахыг зөвшөөрсөн тухай бичиг баримт болон тэнд ажиллаж байгаа бичил уурхайчдын ажиллах зөвшөөрлийн бичиг бүрэн байх; болон 2. Усны бохирдлыг аль болох бага байлгах чиглэлээр ажилладаг байх, усны бохирдлын хяналтын төлөвлөгөө, тоо баримтыг үзүүлнэ.^{29,30} 3. Бичил уурхайн байгууллага нь биологийн төрөл зүйл бүхий газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг Байгаль орчны асуудал хариуцсан захиргааны байгууллагатай зөвлөлдөж тодорхойлох; өндөр ач холбогдол бүхий хамгаалагдсан газар нутаг эсэхийг тодорхойлох зорилгоор биологийн төрөл зүйлийн нэгдсэн үнэлгээний [1] мэдээллийг ашиглах 4. Биологийн төрөл зүйлийн нэгдсэн үнэлгээний[1] мэдээллийг ашиглаж олборлолтын газрын биологийн тогтцын талаарх үнэлгээ хийсэн байна; Олборлолт хийж дууссан газарт нөхөн сэргээлт хийнэ.
<p>В2. Хэрэв бичил уурхайн байгууллага онцгой ач холбогдол бүхий хамгаалагдсан газар нутагт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнийг сольж өөр газар ажиллах боломжгүй бол олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч ажиллана. Мөн түүнчлэн байгаль орчинд нөлөөлөх бусад эрсдэлийг тодорхойлж үнэлгээ хийсэн байна.</p>	<p>Бичил уурхайн байгууллага дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Олборлолтын тусгай зөвшөөрөл/лиценз эсвэл газрын зөвшөөрөлтэй байх; болон 2. Холбогдох захиргааны байгууллагатай хамтарч гаргасан - Олборлолтын үйл ажиллагаанаас хүрээлэн байгаа орчин болон усны эх үүсвэрт үзүүлэх нөлөөг бууруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлдэг байх; 3. Хүрээлэн байгаа орчны экосистем, биологийн төрөл зүйл, ойн санг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх тайлан бэлтгэсэн байна.

²⁹ Засгийн газрын бус зэвсэгт бүлэглэл, хамгаалалтын хүчинд шууд ба шууд бус дэмжлэг үзүүлэх талаар (ЭЗХАХБ 2016b, Хавсралт II, догол мөр 3)

³⁰ Засгийн газрын болон хувийн хамгаалалтын хүчний эрсдэлийн менежмент (ЭЗХАХБ 2016b, Хавсралт II, догол мөр 10)

planetGOLD-оос бусад үйл ажиллагаа

Зарим бичил уурхайн байгууллага хамтарч ажилладаг алт худалдан авагчид, цэвэршүүлэгчид, гоёл чимэглэл үйлдвэрлэгчдийн шаардлагаар тодорхой шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах ёстой байдаг. Жишээлбэл, CRAFT дүрмийн Модуль 5-д тодорхойлсон бусад эрсдэлүүдийг авч үзвэл, гурван planetGOLD шалгуурт хамрагдсан эрсдэлээс гадна БУБ-ууд нэмэлт худалдан авагчидтай ажиллах боломжоо нэмэгдүүлэх боломжтой. Модуль 5-ын эдгээр нэмэлт шаардлагууд буюу худалдан авагчдын тодорхойлсон бусад шаардлагыг хангах сонголт нь БУБ болон холбогдох planetGOLD төслийн менежерүүдийн шийдвэрээр байх бөгөөд заавал хийх шаардлагагүй. Энэ шаардлагыг хангаж ажиллах нь тухайн бичил уурхайн байгууллагын сонголт бөгөөд planetGOLD төслийн хувьд заавал дагаж биелүүлэх шаардлага **биш** юм.

Хэрэгжүүлэх үйл явц

planetGOLD хөтөлбөрийн дэмжлэгтэй, үр шим хүртэгч бичил уурхайн байгууллагуудад дараах 4 үе шаттай planetGOLD стандартыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх шаардлага тавьдаг. Үүнд: эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах/сааруулах, баталгаажуулах ба тайлагнах. Бичил уурхайн байгууллага болон planetGOLD төсөл энэ процессыг хариуцаж ажиллах хүнийг томилж ажиллуулна. planetGOLD стандартын хэрэгжилтийг хариуцаж ажиллах хүнийг томилох тухай дэлгэрэнгүй мэдээллийг [Хавсралт I](#)-ээс үзнэ үү.

Бичил уурхайн байгууллага planetGOLD-ын стандартыг дээрх 4 үе шатаар хэрэгжүүлсэн хэрэгжилтийг 3 түвшинд үнэлнэ.:

- ▶ **1-р түвшин:** planetGOLD хөтөлбөрт хамрагддаг бичил уурхайн байгууллагууд менежментийн тогтолцоо бүрдүүлж өөрсдийн үйл ажиллагааны албан ёсны статусыг батлах баримт нотолгоо бүрдүүлэх, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлж нэгтгэн тайлагнана. Энэ үе шатанд бичил уурхайн байгууллага Модуль 3-т тусгаснаар нэн тэргүүнд хамтын ажиллагааг зогсооход хүргэхүйц ямар нэгэн эрсдэл байхгүй гэдгийг баталгаажуулсан баримт нотолгоо гаргана. Гэхдээ [CRAFT-ын Модуль 4 болон planetGOLD-ын шалгуур үзүүлэлтийн В ба С](#) ангилалд багтдаг хамтын ажиллагаагаа зогсоох шаардлагатай боловч зохицуулж болох эрсдэл байж болох юм. Бичил уурхайн байгууллага эдгээр эрсдэлийг бууруулах менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлдэг байх ёстой. Ингэж ажилласан тохиолдолд нэгдүгээр түвшний үнэлгээгээр бичил уурхайн байгууллагын үйл ажиллагааг тодорхой нөхцөлтэйгөөр нийцэж байна гэсэн дүгнэлт гарна.

- ▶ **2-р түвшин:** 6 сарын хугацаанд бичил уурхайн байгууллага planetGOLD стандартын шалгуур үзүүлэлт болон Модуль 4 болон Хавсралт II-т тусгасан эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэн зохицуулсан тухай, эсвэл амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд хэмжигдэхүйц үр дүн гарч байгаа гэдгийг баталгаажуулж тайлагнана. Эдгээр эрсдэлийг бууруулснаар бичил уурхайн байгууллага planetGOLD-ын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзэхээс гадна Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын магадлан шинжилгээний удирдамжийн шаардлагыг ч хангасан байж болно.³¹ Ингэсэн тохиолдолд нийлүүлэлтийн сүлжээний эцсийн оролцогчид болох худалдан авагчдын шалгуур үзүүлэлтүүдийг хангах юм. Бичил уурхайн байгууллага Модуль 3 ба 4 болон Хавсралт II-т тусгасан эрсдэлүүдийг бууруулах, хянах төлөвлөгөөгөө тогтмол хэрэгжүүлж нөхцөл байдлыг үнэлэн хяналтад байлгадаг байна.
- ▶ **(Сонголтоор) 3-р түвшин:** Өмнө дурдсанчлан зарим бичил уурхайн байгууллага хамтарч ажилладаг алтны худалдан авагчид, цэвэршүүлэгчид, гоёл чимэглэл үйлдвэрлэгчдийн шаардлагаар бусад хариуцлагатай үйл ажиллагааны стандартын тодорхой шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаж болно. Эдгээр нэмэлт шалгуур үзүүлэлтүүдийг хангаснаар тухайн бичил уурхайн байгууллага холбогдох санаачилга, стандартын хүрээнд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж болно.





[Хавсралт II](#)-т уг үйл явцын талаар дэлгэрэнгүй танилцуулсан болно.

Баримтжуулалт ба баталгаажуулалт

Бичил уурхайн бүх байгууллагууд нэгдүгээр шатны үнэлгээ хийсний дараа planetGOLD-ын Байгаль орчин болон нийгэмд учруулж байгаа эрсдэлийн үнэлгээний тайлан өгнө. Энэ тайланд эрсдэлийн үнэлгээ, цаашид эрсдэлийг бууруулах төлөвлөгөө болон үйл ажиллагаа, нотолж болохуйц шаардлагыг тусгаснаар planetGOLD-ын шалгуур үзүүлэлтийг хангаж байна гэсэн баримт болно. Бичил уурхайн байгууллагаас энэ ажлыг хариуцуулахаар тусгайлан томилсон ажилтан planetGOLD-ын тухайн улсад асуудал хариуцсан ажилтны дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэнэ. [Хавсралт III](#) -д тайлан бэлтгэх тухай дэлгэрэнгүй мэдээлэл тусгасан.

planetGOLD хөтөлбөр өөрөө planetGOLD-ын Байгаль орчин ба нийгмийн эрсдэлийн үнэлгээний тайланд хөндлөнгийн баталгаажуулалт шаарддаггүй. Харин тайланд тусгасан мэдээллийг ашигт малтмал худалдан авагчдын тавьсан тусгай шаардлагыг хэрэгжүүлэхэд ашиглах боломжтой юм. Бичил уурхайн байгууллага болон ашигт малтмал худалдан авагчдын үйл ажиллагаа хоорондоо ялгаатай учир тодорхой аудит болон баталгаажуулалтын арга барилыг нөхцөл байдалдаа тохируулан тухай бүрд нь тодорхойлох шаардлагатай. Жишээлбэл, худалдан авагчид бичил уурхайн байгууллагын магадлан шинжилгээний тайланд тусгасан үр дүнг зарим нэг тодорхой шаардлагыг хангасан гэж үзэж болно.

³¹ <https://www.legalinfo.mn/law/details/393>

planetGOLD оролцох түвшин	
Хөтөлбөрт хамрагдсаны тодорхойлолт	
	<ul style="list-style-type: none">• Олборлолын газрын сонголт;• planetGOLD хөтөлбөрт хамрагдагч бичил уурхайчидтай энэхүү хөтөлбөрийн, үйл явцыг дагаж мөрдөх, биелүүлэх тухай гэрээ.
planetGOLD Түвшин нэг	
	planetGOLD хөтөлбөрийн ашиг шимийг хүртэгсэд менежментийн тогтолцоо бүрдүүлж өөрсдийн үйл ажиллагааны албан ёсны статусыг батлах баримт нотолгоо бүрдүүлэх, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлж нэгтгэн тайлагнана.
Нэгдүгээр түвшний үнэлгээг баталсны дараа бичил уурхайн байгууллагын үйл ажиллагаа	
planetGOLD Түвшин хоёр	
	planetGOLD хөтөлбөрийн үр шимийг хүртэгсэд албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч бичил уурхайчдын эрсдэл бууруулах системийн үнэлгээний Модуль 4-д тусгасан эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.
Эдгээр эрсдэлийг бууруулснаар бичил уурхайн байгууллага planetGOLD-ын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзэхээс гадна Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын магадлан шинжилгээний удирдамжийн шаардлагыг ч хангасан байж болно. Ингэсэн тохиолдолд нийлүүлэлтийн сүлжээний сүүлийн оролцогчид болох худалдан авагчдын шалгуур үзүүлэлтүүдийг хангах юм.	
planetGOLD Түвшин гурав	
	Эрсдэлийн үнэлгээ хийж бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх: Бичил уурхайн байгууллага үйл ажиллагаанд нь тулгарч болохуйц бусад эрсдэлийг тодорхойлж илэрсэн тохиолдолд шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэн зохицуулна.
Энэ түвшинд planetGOLD-ын хөтөлбөрт хамрагдагч бичил уурхайн байгууллага албан ёсны зах зээлд оролцож болох бөгөөд Хавсралт II-д тусгасан эрсдэл дахин илэрсэн тохиолдолд дахин үнэлгээ хийнэ.	

Ашигласан материал

1. CRAFT, 2018. Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч бичил уурхайчдын эрсдэл бууруулах системийн үнэлгээ, Хувилбар1.0
<http://www.responsiblemines.org/wp-content/uploads/2018/08/2018-07-31-CRAFT-Code-v-EN.pdf>.
2. CRAFT 2.0. 2020. Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч бичил уурхайчдын эрсдэл бууруулах системийн үнэлгээ. Доорх холбоосоор орж үзнэ үү:
<https://www.craftmines.org/en/what-is-craft/>
3. Шударга худалдаа, 2013. Бичил уурхайгаас олборлосон алт болон дагалдах үнэт металлын шударга олборлолтын стандарт.
https://www.fairtradedeutschland.de/fileadmin/DE/04_aktiv_werden/Aktuelle_Kampagnen/Traut_euch/standard_gold_precious_metals_2015.pdf.
4. FATF. 2012-2019. Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх олон улсын стандарт. Парис, Франц 2012-2019. www.fatf-gafi.org/recommendations.html
5. FATF. 2019. Webpage: Мөнгө угаах. Доорх холбоосоор орж үзнэ үү.
<https://www.fatfgafi.org/faq/moneylaundering/#d.en.11223>
6. Ховордсон ан амьтан, ургамал орчин хамгаалах төрийн бус байгууллага, 2017. Цахим хуудас: Нөлөөллийг бууруулах шатлал: No net loss and net positive impact аргачлал. Доорх холбоосоор орж үзнэ үү: https://api.fauna-flora.org/wpcontent/uploads/2017/12/FFI_2015_The-Mitigation-Hierarchy.pdf
7. GEF. 2018. Даян Дэлхийн Байгаль Орчны Сан-2018. Байгаль орчин ба нийгмийн хариуцлагын шинэчилсэн бодлого. <https://www.thegef.org/documents/environmental-and-social-safeguard-standards>
8. LBMA. 2018. Лондонгийн Үнэт Металын Биржийн Холбоо-2018. Хариуцлагатай эх үүсвэрийн хөтөлбөр (Хувилбар 8) Хариуцлагатай алтны удирдамж.
<http://www.lbma.org.uk/assets/downloads/responsible%20sourcing/RGGV820181211.pdf>
9. ILO Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага(1988 Хавсралтыг 2010 оны 6 дугаар сарын 15 нд шинэчилсэн хувилбар). Ажлын байран дах үндсэн зарчим ба эрхийн тухай тунхаглал ба биелэлтийг эргэж шалгах.
https://www.ilo.org/wcmsp5/groups/public/ed_norm/declaration/documents/publication/wcms_467653.pdf
10. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага. Хүүхдийн хөдөлмөр гэж юу вэ?
<https://www.ilo.org/ipecc/facts/lang-en/index.htm>
11. Уул уурхай, ашигт малтмал, металл болон тогтвортой хөгжлийн асуудлаарх Засгийн газар хоорондын чуулган, 2017, Олон улсын засаглалын форум. Бичил уурхайн дэлхийн чиг хандлага: Гол үзүүлэлт ба асуудлын үнэлгээ, Виннипэг, Тогтвортой хөгжлийн олон улсын институт.
<https://www.iisd.org/sites/default/files/publications/igf-asm-global-trends.pdf>

12. Олон Улсын Санхүүгийн Корпораци. 2012. Гүйцэтгэлийн стандарт 6: Биологийн төрөл зүйлийн хамгаалалт ба байгалийн нөөцийн тогтвортой менежмент.
https://www.ifc.org/wps/wcm/connect/topics_ext_content/ifc_external_corporate_site/sustainability-at-ifc/policies-standards/performance-standards/ps6
13. IRMA 2019. Хариуцлагатай уул уурхайн зааварчилгааны баримт бичгийн стандарт. Хувилбар 1.0
https://responsiblemining.net/wp-content/uploads/2019/12/IRMA_Standard_Guidance_Oct2019.pdf
14. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага. 2016. Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрээс гаралтай эрдэс баялгийн хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний магадлан шинжилгээний удирдамж. Гурав дахь хэвлэл, Парис.
<http://dx.doi.org/10.1787/9789264252479-en>
15. Хариуцлагатай үнэт эдлэлийн зөвлөл. 2019 оны 4 дүгээр сар. Үйл ажиллагааны журам.
<https://www.responsiblejewellery.com/files/RJC-COP-April-2019.pdf>
16. Хариуцлагатай үнэт эдлэлийн зөвлөл. 2013 оны 11 дүгээр сар. Стандартын удирдамж.
https://www.responsiblejewellery.com/files/RJC_Standards_Guidance_2013_eng.pdf
17. Ричард М., Мохер П. ба Тэлмер К., Алтны бичил уурхайн үйл ажиллагаанд мөнгөн усны асуудал, бохирдол болон өртөлтийг бууруулах зорилгоор реторт ашиглах нь: Практик гарын авлага. 2014. Хувилбар 1.0, Бичил уурхайн алтны зөвлөл, Викториа, Бритиш Колумбия. ISBN 978-0-9939459-2-2.
18. НҮББОХ. 2013. Мөнгөн Усны Тухай Минаматагийн Конвенц, Бичвэр болон хавсралт. Женев
<http://mercuryconvention.org/Portals/11/documents/Booklets/COP1%20version/Minamata-Convention-booklet-eng-full.pdf>
19. Нэгдсэн Үндэсний Байгууллагын байгаль орчны хөтөлбөр. 2018. Гарын авлага: Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд алтны бичил уурхайн үйл ажиллагааг албажуулах стратеги боловсруулах нь.
https://wedocs.unep.org/bitstream/handle/20.500.11822/26437/formalization_handbook.pdf
20. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр. 2019. Дэлхийн мөнгөн усны үнэлгээ – 2018, Химийн бодис ба эрүүл мэндийн салбар, Женев, Швейцар
<https://wedocs.unep.org/bitstream/handle/20.500.11822/27579/GMA2018.pdf>
21. Нэгдсэн үндэсний байгууллагын Үйлдвэр хөгжлийн байгууллага. 2015. Байгаль орчин нийгмийн хамгааллын бодлого журам.
22. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Сургалт, судлагааны хүрээлэн болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Байгаль орчны хүрээлэн, 2018. Гарын авлага: Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд алтны бичил уурхайн үйл ажиллагааг албажуулах стратеги боловсруулах нь. Женев. Швейцар Уугуул иргэдийн эрхийн тухай Нэгдсэн Үндэсний Байгууллагын тунхаглал. Доорх холбоосоор орж үзнэ үү. www.un.org/esa/socdev/unpfii/documents/DRIPS_en.pdf
23. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Групп. 2009. Уугуул иргэдийн асуудлын талаархи удирдамж. Доорх холбоосоор орж үзнэ үү:
https://www.un.org/esa/socdev/unpfii/documents/UNDG_guidelines_EN.pdf

ХАВСРАЛТУУД

Хавсралт I: Ажил хариуцах хүн томилох процесс

planetGOLD Монгол төсөл уг хөтөлбөрт хамрагдах бичил уурхайн байгууллагатай planetGOLD стандартын хэрэгжилтийг хангах, үр дүнг баримтжуулах, баталгаажуулах чиглэлээр хамтарч ажиллана. ДДБОС-аас хэрэгжүүлж буй бүх төсөл хөтөлбөрүүд тус сангийн Байгаль орчин, нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх үүрэгтэй байдаг.

planetGOLD хөтөлбөр гүйцэтгэгч агентлагууд planetGOLD стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор бичил уурхайн байгууллагыг хариуцаж, хамтарч ажиллах, удирдан чиглүүлэх үүрэгтэй мэргэжилтнийг томилж ажиллуулна. **Тухайн мэргэжилтэн** нь дараах чиглэлээр ажиллана. Үүнд:


- ▶ Бичил уурхайн байгууллагуудтай тогтмол нягт уялдаа холбоотой ажиллана.³²
- ▶ Бичил уурхайн байгууллагын өөрийн үнэлгээ/аудит болон гэрээт ажлын үнэлгээ/аудитыг зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлж, ажиглаж, хянана.
- ▶ Бичил уурхайн байгууллагад бичиг баримт бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

Хэрэгжилтийг хөнгөвчлөхийн тулд бичил уурхайн байгууллагууд planetGOLD стандарттай холбоотой бүх мэдээлэл, аливаа хүсэлтийг хянах, удирдах, мэдээлэх үүрэг бүхий нэг ажилтныг томилох ёстой. Энэ ажилтан нь тухайн **бичил уурхайн байгууллагыг төлөөлөн ажиллах хүн** бөгөөд дараах үүрэг хариуцлага хүлээнэ. Үүнд:

- ▶ Уг ажилтан нь бичил уурхайн байгууллагаа төлөөлж холбогдох бүх асуудлыг удирдан зохион байгуулах бөгөөд planetGOLD хөтөлбөрийн мэргэжилтэнтэй тогтмол уулзаж, хамтран ажиллана.
- ▶ planetGOLD шалгуур үзүүлэлт, стандартын шаардлагыг чанд дагаж мөрдөхөө бичгээр илэрхийлсэн байна.
- ▶ Байгууллагын үйл ажиллагаандаа бүх төрлийн аудит, үнэлгээ хийж ажиллах бөгөөд planetGOLD-ын тухайн улсад ажиллаж байгаа төслийн асуудал хариуцсан мэргэжилтнийг шаардлагатай мэдээллээр тогтмол хангана.
- ▶ planetGOLD-ын тухайн улсад ажиллаж байгаа төслийн холбогдох мэргэжилтний дэмжлэгтэйгээр хамтарч ажиллана.

³² Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам:
<https://www.legalinfo.mn/annex/details/7870?lawid=12681>

Хавсралт II: planetGOLD стандартыг хэрэгжүүлэх процесс

planetGOLD оролцоо		Шалгуур үзүүлэлт холбогдох материал
<p>Хөтөлбөрт оролцогсдын тодорхойлолт</p> <ul style="list-style-type: none"> Олборлолтын газрын сонголт planetGOLD хөтөлбөрт хамрагдах бичил уурхайчидтай байгуулсан гэрээ. Үүнд процесс хэрхэн явуулахыг тусгасан байна. 		
<p>planetGOLD Түвшин нэг</p> <p>planetGOLD хөтөлбөрт хамрагдагсад үйл ажиллагааны менежментийн тогтолцоо бүрдүүлж байгууллагынхаа албан ёсны үйл ажиллагаа явуулдаг гэдгийг батлах гэрчилгээ, бичиг баримтыг бүрдүүлнэ. Мөн түүнчлэн байгууллагын үйл ажиллагаанд тулгарч байгаа эрсдэлийн талаар тайлан бэлтгэж өгнө.</p>		
	<p>Менежментийн тогтолцоо бүрдүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> Бичил уурхайчдын байгууллага болон planetGOLD төслөөс стандартын хэрэгжилтийг хариуцах ажилтныг томилно. Эдгээр ажилтнууд шаардлагатай харилцаа холбооны систем бүрдүүлнэ. Стандартын шалгуур үзүүлэлтийн биелэлтийг баталгаажуулах, үүнийг хянах, баримтжуулах тогтолцоо бүрдүүлнэ. Мөн түүнчлэн бүх биелэлтийг нотлох баримтууд байх. Энэ тогтолцооны талаар сургалт зохион байгуулна. 	<p>МОДУЛЬ 1: Менежментийн тогтолцоо бүрдүүлэх</p>
	<p>Бичил уурхайн байгууллага албан ёсоор үйл ажиллагаа явуулдаг байна: planetGOLD хөтөлбөрийн шаардлагын дагуу албан ёсоор үйл ажиллагаа явуулдаг байх.</p> <p>Бичил уурхайн байгууллага дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан гэдгийг нотлоно. Үүнд</p> <ul style="list-style-type: none"> Шууд ба шууд бус хэлбэрээр албадан хөдөлмөр эрхлүүлэх асуудал гардаггүй. Үүнд мөн хүүхдийн хөдөлмөр эрхлэлт орно. Хүний эрхийг зөрчсөн ямар нэгэн үйл ажиллагаанд оролцдоггүй, холбогдоогүй. Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрт ойр байрладаг эсэх талаар мэдэгдсэн. Зэвсэгт мөргөлдөөн, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон хүч амыг хомголон устгах үйл ажиллагаатай холбогдоогүй. Засгийн газрын бус зэвсэгт бүлэглэлүүдийн зүгээс хууль бус хяналт тавих, татвар төлбөр ногдуулах, мөнгө, ашигт малтмал хурааж авах асуудалд ороогүй. 	<p>МОДУЛЬ 2: Бичил уурхайн байгууллагын албан ёсны статус</p> <p>МОДУЛЬ 3: Хавсралт II нэн даруй зогсоох шаардлагатай эрсдэл</p>
	<p>Бичил уурхайн байгууллага дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан гэдгийг нотлоно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Засгийн газрын бус зэвсэгт бүлэглэлүүдийн хууль бус хяналтад байдаггүй. Хүний эрх, олборлолтын газрыг хууль журмын хүрээнд хамгаалдаг. Хүний эрхийн ноцтой зөрчил үүсгэж байсан хамгаалах бүлгийг мэдсээр байж ажиллуулдаггүй. Татвар, хураамж болон нөөц ашигласны төлбөрийн талаар худал мэдүүлэхээс зайлсхийх. Хээл хахууль санал болгох, амлах, эсвэл шаардах асуудал гарахаас сэргийлэх бүх талын арга хэмжээ авдаг. Мөнгө угаах ажлыг үр дүнтэй халах ажлыг дэмждэг. 	<p>МОДУЛЬ 4: Хавсралт II зохицуулах арга хэмжээ авсан ч амжилтгүй болсон тохиолдолд хэмтэн ажиллагаагаа зогсоох шаардлагатай эрсдэл</p>
	<p>Уул уурхайн байгууллага нь дараах planetGOLD шалгуурыг хангасан гэсэн баталгаатай мэдэгдлийг гаргаж өгнө:</p> <p>(A) Олборлолтын үйл ажиллагаанд мөнгөн усны хэрэглээг халах, химийн хорт бодис болон хаягдлын зохистой менежмент бүрдүүлэх</p> <p>(Б) Даян дэлхийн байгаль орчны сангийн Байгаль орчин, нийгмийн хамгааллын шаардлагын дагуу нутгийн уугуул иргэдийн ашиг сонирхолыг хүндэтгэх;</p> <p>(B) Биологийн төрөл зүйлд учруулах нөлөөг багасгах.</p> <p>Эрсдэлийг үнэлж бууруулах: Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч бичил уурхайчдын эрсдэл бууруулах системийн үнэлгээний Модуль 4-д тусгасан эрсдэл болон planetGOLD-ийн шалгуур үзүүлэлтийг хараахан бууруулж, хангаж чадаагүй бол цаашид зохицуулах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан байна.</p> <p>Тайлагнах: Тайлан дээр дурдсан бүх асуудлын талаарх мэдээллийг бүрэн гүйцэд харьцуулан тусгасан байна.</p> <p>Биелэлтийн үнэлгээ: Эцсийн тайланг хүлээж авснаар дээрх шаардлагуудын биелэлтийг баталгаажуулсан гэж тооцно.</p>	 <p>planetGOLD Стандартын шалгуур үзүүлэлт</p>
<p>Түвшин нэгийн үнэлгээг хийж баталсан тохиолдолд тухайн байгууллагын тодорхой нөхцөлтэйгөөр стандартын шаардлагыг биелүүлсэн гэж үзнэ.</p>		

planetGOLD Түвшин хоёр

Албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч бичил уурхайчдын эрсдэл бууруулах системийн үнэлгээний Модуль 4-д тусгасан эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө болон planetGOLD стандартын дагуу сайжруулах шаардлагатай эрсдэлийг сааруулах төлөвлөгөөгөө хэрэгжүүлж ажиллана.



Эрсдэлийг үнэлж бууруулах:

6 сарын хугацаанд бичил уурхайн байгууллага Модуль 4 болон planetGOLD стандартын дагуу хийсэн эрсдэлийн үнэлгээ болон сайжруулах процессыг гүйцэд хэрэгжүүлж эрсдэлийг хяналтад авсан үр дүнг баримтжуулж баталгаажуулсан байна.



Тайлагнах: Тайланд дээр дурдсан бүх асуудлын талаарх мэдээллийг бүрэн гүйцэд харьцуулан тусгасан байна.

Биелэлтийн үнэлгээ: Эцсийн тайланг хүлээж авснаар дээрх шаардлагуудын биелэлтийг баталгаажуулсан гэж тооцно.

Эдгээр эрсдэлийг бууруулснаар бичил уурхайн байгууллага planetGOLD-ын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзэхээс гадна Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын магадлан шинжилгээний удирдамжийн шаардлагыг ч хангасан байж болно. Ингэсэн тохиолдолд нийлүүлэлтийн сүлжээний сүүлийн оролцогчид болох худалдан авагчдын шалгуур үзүүлэлтүүдийг хангах юм.

Хүснэгт 2: planetGOLD стандартын 2-р түвшин

planetGOLD Түвшин гурав		Шалгуур үзүүлэлтийн холбогдох материал
	Эрсдэлийг үнэлж бууруулах: Бичил уурхайн байгууллага дээр дурдсанаас бусад ямар нэгэн эрсдэл байгааг илрүүлсэн бөгөөд сайжруулах тохиолдолд түүнийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	Хавсралт II-д тусгаагүй бууруулах шаардлагатай өндөр эрсдэл
	Тайлагнах: Зах зээлд орох түвшинд тавигдах бүх шаардлагын талаарх мэдээллийг тайлагналд бүрэн гүйцэд харьцуулан тусгасан байна.	
Энэ түвшинд planetGOLD-ын хөтөлбөрт хамрагдагч бичил уурхайн байгууллага албан ёсны зах зээлд оролцож болох бөгөөд Хавсралт II –д тусгасан эрсдэл илэрсэн тохиолдолд дахин үнэлгээ хийнэ.		

Хүснэгт 3: planetGOLD стандартын 3-р түвшин

Хавсралт III: Баримтжуулах процесс

Бичил уурхайн байгууллагаас стандартын хэрэгжилтийг хариуцах ажилтан болон **planetGOLD-ын тухайн улсад хэрэгжиж байгаа төслөөс хариуцах мэргэжилтнээ** томилсны дараа энэ хоёр ажилтан хамтарч planetGOLD-ын Байгаль орчин ба нийгмийн эрсдэлийн үнэлгээний тайлан бэлтгэснээр тухайн бичил уурхайн байгууллага planetGOLD-ын [нэгдүгээр түвшний шалгуур](#) үзүүлэлтийг хангах боломжтой болно. Энэ тайланд шаардсан бүх мэдээллийг тусгасан байхаас гадна бичил уурхайн байгууллагын зүгээс CRAFT-ын Модуль 4-д тусгасан эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, эсвэл planetGOLD стандартын дагуу сайжруулах шаардлагатай эрсдэл гэх мэт бүх холбогдох мэдээллийг нэгтгэн оруулсан байна.

Баримтжуулахад дараах материалыг бэлтгэсэн байхаас гадна бусад нэмэгдэл материалыг оруулж болно. Үүнд:

- ▶ Олборлолт явуулах зөвшөөрөл (АМГТГ-аас авсан газрын дүгнэлт, Аймгийн ИТХ-ээс тусгай хэрэгцээнд авсан эсэх, Сумын Засаг даргатай хийсэн гэрээ),
- ▶ Бичил уурхайн байгууллагын гэрчилгээ, бичиг баримт, тухайн байгууллага болон түүний гишүүд хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулдаг гэдгийг батлах баримтууд,
- ▶ Бичил уурхайн байгууллагын үйл ажиллагаа явуулдаг газрын мэдээлэл, олборлолтын үйл ажиллагааны ерөнхий танилцуулга, бичил уурхайчдын тоо, тэдний нас, хүйсийн мэдээллийг багтаасан хүснэгт,
- ▶ Олборлолтын газрын байршил, үүнд харьяалагдах байгууламж болон эргэн тойрны байдал, байгууламжийг харуулсан газрын зураг,
- ▶ Үнэлгээгээр илрүүлсэн эрсдэлийн матриц
- ▶ Эрсдэлийг бууруулах тодорхой хугацаатай нарийвчилсан төлөвлөгөө байна.

Тайланг planetGOLD-ын тухайн улсад хэрэгжиж буй төслийн менежерт хүргэнэ. Менежер тайлантай танилцсаны дараа хүлээж авч батална. Бичил уурхайн байгууллагын энэхүү тайланг хүлээн авч баталсан тохиолдолд тухайн байгууллагыг тодорхой нөхцөлтэйгөөр **planetGOLD стандартын шаардлагыг** биелүүлсэн байна гэж үзэх бөгөөд бичил уурхайн байгууллага цаашид төлөвлөсний дагуу илрүүлсэн эрсдэлүүдийг бууруулах төлөвлөгөөгөө хэрэгжүүлж, хянаж, төслийн хариуцсан мэргэжилтэнтэй тохирсон хугацаанд тогтмол тайлагнаж байна.³³ Хэрэв бичил уурхайн байгууллагын тайлан батлагдаагүй тохиолдолд тухайн байгууллага илэрсэн зөрчлийг тодорхой хугацаанд арилгаж дахин үнэлгээ, шалгалт хийх даалгавар авна. Зөрчлийг засаж залруулсны дараа тайланг дахин бэлтгэж төслийн менежерт хүргэх бөгөөд менежер хүлээн авч баталсан тохиолдолд тухайн байгууллагыг тодорхой нөхцөлтэйгөөр **planetGOLD стандартын шаардлагыг** биелүүлж байна гэж үзнэ.

Бичил уурхайн байгууллагын тайланг баталсны дараа тухайн байгууллага CRAFT-ын Модуль 4-д тусгасан эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө болон planetGOLD стандартын дагуу сайжруулах шаардлагатай эрсдэлийг бууруулах төлөвлөгөөгөө хэрэгжүүлж ажиллана. Үүнээс 6 сарын дараа **бичил уурхайн байгууллагын асуудал хариуцсан ажилтан** эрсдэлийн үнэлгээ болон сайжруулах процессыг гүйцээж үр дүнг баримтжуулна. Үүний дараа бичил уурхайн байгууллага [planetGOLD стандартын 2-р түвшний](#) шаардлагыг хангах зорилгоор эрсдэл бууруулсан тухай тайлан бэлтгэж төслийн асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргэж хянуулан улмаар төслийн менежерт хүргэж батлуулна. Ийнхүү тулгарч байсан эрсдэлийг бууруулснаар бичил уурхайн байгууллагыг **planetGOLD стандартын шаардлагыг** биелүүлсэнд тооцно.

Хавсралт IV: Нэр томъёоны тайлбар

Амальгам хийх (мөнгөн усаар алт бариулах) гэдэг нь мөнгөн ус ашиглан алтны ширхэглэгүүдийг цуглуулж алт, мөнгөн усны амальгам буюу нэгдэл үүсгэсний дараа ууршуулах замаар алтыг ялгаж авах, ашигт малтмалыг баяжуулах арга юм.

Эх үүсвэр: (CRAFT 2018)

Бичил уурхай гэдэг нь ихэвчлэн хамгийн энгийн аргаар ашигт малтмал хайх, олборлох, баяжуулах болон тээвэрлэх албан болон албан бус үйл ажиллагаа юм. Бичил уурхайгаар голдуу хөрөнгө мөнгө бага, харин хүн хүч их шаардагдах технологи ашиглаж ашигт малтмал олборлодог. Бичил уурхайн үйл ажиллагаанд хүүхэд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд оролцож болох ба ганцаараа, гэр бүлээрээ бүлэг, нөхөрлөл үүсгэж, эсвэл хэдэн зуун, мянган гишүүнтэй хууль ёсны холбоо, аж ахуйн нэгж байгуулж ажилладаг.

*Бичил уурхайн тодорхойлолт нь улс орон бүрд, улс орон дотроо салбар бүрд өөр өөр байдаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм.

Эх үүсвэр: (ЭЗХАХБ 2016)

Биологийн төрөл зүйл гэдэг нь бүх төрлийн амьд организмын доторх олон янз байдлыг хэлнэ. Үүнд төрөл зүйл доторх олон төрөл, төрөл зүйлүүдийн хоорондох ялгаатай байдал болон экосистемийн доторх төрлүүд, төрөл зүйлийн хоорондын холбоо, хуурай газрын, далай тэнгисийн болон усанд оршдог бүх төрлийн экологийн амьд биетүүд багтана.

Эх үүсвэр: (ДДБОС 2018)

Дотоодын төрийн байгууллагын албан тушаалтанд авилга, хээл хахууль өгөх гэдэг нь төрийн байгууллагын албан тушаалтныг албан үүргээ зохих ёсоор нь гүйцэтгэхээс татгалзуулах зорилгоор шууд ба шууд бусаар, өөр хүн болон байгууллагаар дамжуулж авилга, хээл хахууль амлах, санал болгох, өгөх; эсвэл төрийн байгууллагын албан тушаалтан албан үүргээ зохих ёсоор нь гүйцэтгэхээс татгалзаж шууд ба шууд бусаар, өөр хүн болон байгууллагаар дамжуулж авилга, хээл хахууль шаардахыг хэлнэ.

Эх үүсвэр: (CRAFT 2018)

Гадаадын төрийн байгууллагын албан тушаалтан, олон улсын байгууллагын ажилтанд авилга, хээл хахууль өгөх гэдэг нь гадаадын төрийн байгууллагын албан тушаалтан, олон улсын байгууллагын ажилтанд албан үүргээ зохих ёсоор нь гүйцэтгэхээс татгалзуулах, олон улсын түвшний үйл ажиллагаа явуулахтай холбоотой ашиг хонжоо олох зорилгоор санаатайгаар шууд ба шууд бусаар, өөр хүн болон байгууллагаар дамжуулж авилга, хээл хахууль санал болгох, өгөхийг хэлэх бөгөөд энэ нь эрүүгийн гэмт хэрэг юм.

Эх үүсвэр: (CRAFT 2018)

Орон нутгийн иргэд гэдэг нь газарзүйн хувьд нэг байршилд оршин суудаг эсвэл нэгдсэн нэг хүсэл зорилготой бүлэг хүмүүсийг хэлнэ. Эдгээр хүмүүс ихэвчлэн ижил итгэл үнэмшил, үнэт зүйлтэй байдаг. Тухайн орон нутагт өрнөж буй үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдэд эерэг болон сөрөг үр нөлөө үзүүлж болно.

Эх үүсвэр: (Хариуцлагатай үнэт эдлэлийн зөвлөл 2019)

Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэр гэдэг нь ЭЗХАХБ-ын (2016b) тодорхойлсноор гэмт хэргийн сүлжээгээр бий болсон хүчирхийлэл, эсвэл хүмүүст учруулах аюул, бусад ноцтой эрсдэл зэрэг зэвсэгт мөргөлдөөн, олон нийтийг хамарсан хүчирхийлэл бүхий газар нутгуудыг хэлнэ. Зэвсэгт мөргөлдөөн нь олон улсын болон олон улсын бус шинж чанартай мөргөлдөөн, нэг буюу түүнээс дээш улсыг хамарсан, эсвэл чөлөөлөх дайн, бослого, иргэний дайн зэрэг олон янзын хэлбэртэй байж болно. Эрсдэл өндөртэй газар нутгууд гэж мөргөлдөөн, эсвэл олон нийтийг хамарсан, ноцтой зөрчлийн эрсдэл ихтэй газар нутгийг хэлнэ. Энэхүү газар нутгийг ихэвчлэн улс төрийн тогтворгүй байдал, хэлмэгдүүлэлт, институцийн сул чадавх, тайван амгалан бус байдал, нийтийн дэд бүтэц нь эвдэрч нурсан, хүчирхийлэл газар авсан байдал, үндэсний хийгээд олон улсын хууль тогтоомж зөрчигдсөн байдлаар онцлон тодорхойлж болно.

Эх үүсвэр: (CRAFT 2018); (ЭЗХАХБ 2016b)

Хүүхдийн хөдөлмөр гэдэг нь хүүхэд нас, хөгжих боломж, хүний эрхэм чанарыг үгүйсгэж тэдний бие бялдар, оюун ухааны хөгжилд сөрөг нөлөө учруулах ажлыг хэлнэ. Үүнд оюун ухаан, бие махбод, нийгмийн болон ёс суртахууны хувьд аюултай, хүүхдэд хор нөлөөтэй, хүүхдийн суралцах боломжийг хязгаарлаж улмаар сургуулиа орхиход хүргэдэг учраас хүүхдийн сурч боловсроход саад болох, хүнд хэцүү ажлыг удаан хугацаагаар сургуульд суралцахтай хослуулан хийх шаардлагатай бүх ажил багтана. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт боолчлол, гэр бүлээс нь салгаж ажиллуулах, аюултай болон өвчний эх үүсвэртэй орчинд ажиллуулах, бага насны хүүхдийг том хот суурин газарт харах хамгаалах хүнгүйгээр орхих зэрэг орно. Харин тодорхой зарим ажлыг хүүхдийн хөдөлмөр гэж нэрлэх эсэхийг хүүхдийн нас, ажлын төрөл, цаг, ажиллах нөхцөл, үүнээс гарах үр дүнгээс шалтгаалж улс орон бүр өөр өөрийнхөөрөө тухайн салбар, улс орны онцлогоос хамааран тодорхойлдог.

Эх үүсвэр: (ОУХБ 2013) (Цахим хуудас: [Хүүхдийн хөдөлмөр гэж юу вэ?](#))

Дагаж мөрдөх гэдэг нь тодорхой дүрэм, журам, тодорхойлолт болон хууль эрхзүйн заалтын дагуу ажиллахыг хэлнэ.

Эх үүсвэр: (ХҮЭЗ 2019)

CRAFT МОДУЛЬ:

МОДУЛЬ 1: Байгууллагын менежментийн тогтолцоо бүрдүүлэх нь Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын 5 алхамт магадлан шинжилгээний үнэлгээний анхны алхам юм. Энэ Модуль нь 4 шаардлагатай.

МОДУЛЬ 2: Бичил уурхайн байгууллагын албан ёсны байдал.

МОДУЛЬ 3: НЭН ДАРУЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ЗОГСООХ ШААРДЛАГАТАЙ “ХАВСРАЛТ II-Т ТУСГАСАН ЭРСДЭЛ” нь Хавсралт II буюу Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын магадлан шинжилгээний удирдамжид зөвлөмж болгосноор тодорхой эрсдэлүүд тухайн бичил уурхайн байгууллагын үйл ажиллагаанд илэрсэн тохиолдолд ашигт малтмал худалдан авагсад хамтын ажиллагаагаа нэн даруй зогсоох шаардлагатай эрсдэлүүдийг тусгасан бөгөөд энэ төрлийн эрсдэл байна гэж үзсэн тохиолдолд магадлан шинжилгээний удирдамжийг дагаж мөрддөг худалдан авагчид хамтын ажиллагаагаа зогсоодог. Иймээс энэ Модулийн бүх шаардлага зөвхөн тэнцсэн эсвэл тэнцээгүй гэсэн шалгууртай байна.

МОДУЛЬ 4: ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОЛДЛОГО АМЖИЛТГҮЙ БОЛСНЫ ДАРАА ЗОГСООХ ШААРДЛАГАТАЙ “ХАВСРАЛТ II-Д ТУСГАСАН ЭРСДЭЛ”-д Хавсралт II буюу Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын магадлан шинжилгээний удирдамжид зөвлөмж болгосноор тодорхой эрсдэлүүдийг бууруулах ажил хийгдсэн боловч нөхцөл байдал сайжраагүй тохиолдолд хамтын ажиллагаагаа түр зогсоох эсвэл зогсоох шаардлагатай эрсдэлүүдийг тусгасан. Энэ Модулийн бүх шаардлагад тэнцсэн, ахиц дэвшилтэй, эсвэл тэнцээгүй гэсэн шалгууртай байна.

МОДУЛЬ 5: “ХАВСРАЛТ II-Д ТУСГААГҮЙ” ЗАЛРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ӨНДӨР ЭРСДЭЛ нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын магадлан шинжилгээний удирдамжийн “Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрт ашигт малтмалын олон улсын хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээ бүрдүүлэх загвар нийлүүлэлтийн сүлжээний бодлого”-д тусгайлан тусгаагүй өндөр эрсдэлийг авч үзэх бөгөөд Хавсралт II-д тусгаагүй эрсдэл гэж тодорхойлсон. Модуль 5-ын шаардлагууд нь зарчмын хувьд тухайн байгууллага үйл ажиллагаагаа улам сайжруулахыг хүсэх тухай боловч эдгээр өндөр эрсдэлийг бууруулж, үйл ажиллагаагаа сайжруулж чадаагүй тохиолдолд худалдан авагчид бичил уурхайн байгууллагын энэ байдал нь өөрсдийн бизнест эрсдэл үүсгэх магадлалтай гэж үзэн хамтын ажиллагаагаа зогсоох эрсдэлтэй юм.

Эх үүсвэр: Vol. 2B & Vol 4 (CRAFT 2.0, 2020)

CRAFT систем нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын магадлан шинжилгээний удирдамжтай уялдуулан бичил уурхайчдын оролцоотой нийлүүлэлтийн сүлжээнд хэрэгжүүлэх систем юм. Энэ системийг хэрэгжүүлж байгаа хэлбэрээс шалтгаалан өмчийн шинж чанартай байж болно.

Эх үүсвэр: (CRAFT 2018)

Ховордсон төрөл зүйл гэдэг нь биологийн төрөл зүйлийг хадгалах өндөр ач холбогдол бүхий (i) Олон улсын байгаль хамгаалах холбооны улаан жагсаалт болон үндэсний улаан номд орсон ховордож устах аюулд тулгарсан нэн ховор болон ховор амьтан, ургамал, (i i) Эндэмик болон хориотой бүсийн төрөл зүйл, (i i i) Дэлхийн болон үндэсний хэмжээнд нүүдлийн болон суурин байдаг амьтан ургамлын дэмждэг төрөл зүйл, (i v) устаж үгүй болох өндөр эрсдэлтэй болон онцгой экологийн систем, болон (v) (i) болон (v)-д заасан биологийн төрөл зүйлийн хэвийн байдлыг хангах экологийн үйл явц, шинж чанарыг хэлнэ.

Эх үүсвэр: (ДДБОС 2018)

Соёлын өв гэдэг нь биет болон биет бус соёлын өвийг хэлнэ. Үүнд орон нутгийн иргэд, хамт олон, нөхөрлөл, бүлгүүд болон зарим тохиолдолд хувь хүн өөрсдийн үеэс үед дамжиж ирсэн соёлын өв гэж үздэг бөгөөд байнга арчилж тордон сэргээн засварладаг хөдөлгөөнтэй болон суурин эд зүйлс, газар нутаг, бүтэц, байгалийн үзэгдэл, археологийн, палеонтологийн, түүхийн, архитектурын, шашны, гоо зүйн болон бусад соёлын ач холбогдолтой хөдөө орон нутаг болон хот суурин газрын гадаргууд, газар гүнд, усан доор байрлах газар, зан үйл, дүрслэл, илэрхийлэл, мэдлэг, чадвар, зэмсэг, эд зүйлс, объект болон эдгээрийг агуулж байгаа соёлын орон зай орно.

Эх үүсвэр: (ДДБОС 2018)

Засгийн газрын бус зэвсэгт бүлэглэлүүдэд шууд ба шууд бусаар дэмжлэг үзүүлэх

гэдэг нь засгийн газрын болон засгийн газрын бус хамгаалалтын хүчин, эсвэл тэдгээртэй холбоотой этгээдүүд буюу (a) олборлолтын газар, тээврийн замууд, алт худалдаалах цэгүүд болон нийлүүлэлтийн сүлжээний эхэнд байх уурхайчдыг хууль бусаар хянаж буй этгээд, (b) олборлолтын газар, ашигт малтмал худалдах цэгүүд, эсвэл тээврийн замын дагуу хууль бусаар татвар мөнгө, эсвэл эрдэс баялаг авдаг, болон (c) зуучлагчид, экспортын компаниуд эсвэл олон улсын худалдаачдаас хууль бусаар татвар авах, сүрдүүлдэг этгээдээс эрдэс баялаг худалдаж авах, төлбөр төлөх, тоног төхөөрөмж болон логистикийн тусалцаа үзүүлэх зэргийг хамруулж үзнэ.

Эх үүсвэр: (ЭЗХАХБ 2016b)

Нийлүүлэлтийн сүлжээний доод хэсэг (Downstream) гэдэг нь бичил уурхайгаар олборлосон алтыг худалдан авагч, алт цэвэршүүлэгчдийг хэлнэ.

Эх үүсвэр: (CRAFT 2018)

Магадлан шинжилгээ (Due Diligence) гэдэг нь компаниудад бизнесийн шийдвэр гаргах болон эрсдэлийн менежментийн тогтолцооны хэсэг болох бодит болон болзошгүй сөрөг нөлөөллийг хэрхэн тодорхойлох, урьдчилан сэргийлэх, бууруулах замаар тасралтгүй үргэлжлэх, нөхцөл байдалд тохируулан хүлээн авч хариу үйлдэл хийх процесс юм. Магадлан шинжилгээ нь компаниудад НҮБ-ын хориг арга хэмжээ, эрдэс баялгийн хууль бус худалдааг зохицуулах хууль зэрэг олон улсын болон дотоодын хууль тогтоомжийн зарчмуудыг дагаж мөрдүүлэхэд тусална.

Эх үүсвэр: (ЭЗХАХБ 2016b)

Эдийн засгийн өөрчлөлт гэдэг нь олборлолтын газар, хөрөнгө, эсвэл олборлолтын газар болон хөрөнгө, тоног төхөөрөмж ашиглах боломжоо алдах, газар ашиглахад тавьсан хориг зэргээс түр болон бүр орлогын эх үүсвэр, эсвэл амьжиргааны эх үүсвэрээ алдахыг хэлнэ.

Эх үүсвэр: (ДДБОС 2018)

Албажуулалт гэдэг нь бичил уурхай эрхлэгчид өөрсдийн эрх ашгийг төлөөлөх байгууллагад нэгдэж олборлолтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авч ажиллахыг баталгаажуулах үйл явц юм. Үүнд холбогдох бодлого, хууль журмыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах, бичил уурхай эрхлэгчид эдгээр хууль, дүрэм, журмыг дагаж мөрдөх боломжийг бүрдүүлэх техникийн, захиргааны болон санхүүгийн тусламж дэмжлэг авдаг байх зэрэг цогц асуудал орно.

Эх үүсвэр: (UNITAR & UN Environment 2018)

Жендэрт суурилсан хүчирхийлэл гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондох нийгмийн ялгаанд суурилсан нийтийн дунд болон далдуур тухайн хүний хүслийг үл харгалзан үйлдсэн бие махбод, сэтгэцийн болон бэлгийн дарамт үзүүлэх, айлган сүрдүүлэх, эрх чөлөөг хаан боогдуулах гэх мэт хор нөлөөтэй үйлдлийг хэлнэ.

Эх үүсвэр: (ДДБОС 2018)

Жендэрийн эрх тэгш байдал гэдэг нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүд тэгш эрх, хариуцлага, боломжтой байхыг хэлнэ. Энэ нь эмэгтэй болон эрэгтэй хүн болж төрснөөс шалтгаалахгүйгээр эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн тэгш эрхтэй байхыг хэлнэ.

Эх үүсвэр: (ДДБОС 2018)

Санал, гомдол гаргах үйл явц гэдэг нь хувь хүн болон бүлэг этгээд байгууллагын зүгээс тэдэнд үзүүлж байгаа нөлөө, тэдний эрхийг зөрчиж байгаа талаар санал бодлоо албан ёсоор илэрхийлж, зөв шийдэл эрэлхийлсэн шүүхийн бус үйл явц юм. Энэ механизм нь шийдвэр гаргах, тохиролцох гэх мэт зохистой бөгөөд хүний эрхэд суурилсан үйл явц байна.

Эх үүсвэр: (CRAFT 2018)

Хүний эрхийн ноцтой зөрчил CRAFT-д тодорхойлсноор Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Олон улсын хүмүүнлэгийн хууль эрхзүйн актад хүний эрхийн ноцтой зөрчлийн тодорхойлолт дутмаг байдаг байна. Хүн төрөлхтний эсрэг хамгийн ноцтой гэмт хэрэг бол: (a) хүн төрөлхтнийг хоморголон устгах; (b) хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг; (c) зэвсэгт мөргөлдөөн; болон (d) халдан түрэмгийлэх үйлдэл юм.

ЭЗХАХБ МШҮ-ийн Хавсралт II-д:

1. **Эрдэс баялаг олборлох, тээвэрлэх, худалдахтай холбоотой ноцтой зөрчлийн талаар:** Зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрт ажиллаж байхдаа, эсвэл энэхүү төрлийн нутаг дэвсгэрээс эрдэс баялаг авч ашиглахдаа бид аливаа этгээдийн дараах үйлдлийг дэмжих, туслах, эсвэл санхүүжүүлэх зэрэг ямар нэг хэлбэрээр оролцохыг хориглодог.
2. **Ноцтой зөрчлийн эрсдэлийн менежментийн талаар:** 1-р зүйлд тодорхойлсон ноцтой зөрчил гаргасан аливаа этгээдтэй холбоотой, эсвэл эрсдэлтэй гэж үзсэн бэлтгэн нийлүүлэгчидтэй бид харилцаа холбоогоо нэн даруй тасалж, хамтарч ажиллахаа болино.³⁴
3. **Засгийн газрын бус зэвсэгт бүлэглэлүүдэд шууд ба шууд бус³⁵ байдлаар дэмжлэг үзүүлэх талаар:** Бид эрдэс баялаг олборлох, тээвэрлэх, худалдах, зөөвөрлөх, экспортлох үйл ажиллагаагаар дамжуулж засгийн газрын бус зэвсэгт бүлэглэлүүдэд шууд ба шууд бус байдлаар дэмжлэг үзүүлэхгүй. “Шууд ба шууд бус дэмжлэг” гэдэгт засгийн газрын бус зэвсэгт бүлэглэлүүд, эсвэл тэдгээртэй холбоотой этгээдүүдээс эрдэс баялаг худалдаж авах, төлбөр төлөх, тоног төхөөрөмж болон логистикийн туслалцаа үзүүлэх зэргийг хамруулж үзнэ.
4. **Шууд ба шууд бусаар дэмжлэг үзүүлэхтэй холбоотой эрсдэлийн менежментийн талаар:** 3-р хэсэгт тодорхойлсон засгийн газрын бус зэвсэгт бүлэглэлүүдэд шууд ба шууд бус дэмжлэг үзүүлдэг аливаа этгээдтэй холбоотой, эсвэл эрсдэлтэй гэж тодорхойлсон нийлүүлэлтийн сүлжээний бэлтгэн нийлүүлэгчидтэй нэн даруй харилцаагаа тасалж, хамтран ажиллахаа болино.³⁶
5. **Засгийн газрын болон хувийн хамгаалалтын хүчний талаар:** Олборлолтын газар, тээврийн замууд болон нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудыг хууль бусаар хянадаг, эрдэс баялаг худалдагдаж буй цэгүүд, тээврийн замын дагуу, уурхайн талбайд нэвтрэх цэг дээр хууль бусаар татвар, мөнгө, эрдэс бүтээгдэхүүн шаардан авдаг, эсвэл зуучлагчид, экспортын компаниуд эсвэл олон улсын худалдаачдаас хууль бусаар татвар төлбөр авдаг засгийн газрын болон хувийн хамгаалалтын хүчинд 10³⁷ дугаар зүйлд заасны дагуу шууд ба шууд бусаар дэмжлэг туслалцаа үзүүлэхгүй.

Эх үүсвэр: (CRAFT 2018); (ICC 2002) (Statue of Rome.); (ЭЗХАХБ 2016)

³⁴ Ашигт малтмал олборлох, тээвэрлэх болон худалдаалах үйл ажиллагаатай холбоотой ноцтой дарамт шахалт, хүчирхийллийн тухай (ЭЗХАХБ 2016b, Хавсралт II, догол мөр 1)

³⁵ Засгийн газрын бус зэвсэгт бүлэглэл, хамгаалалтын хүчнийг тодорхойлоход компаниуд НҮБ-ийн Хамгаалах албаны зөвлөлийн журамыг барина (ЭЗХАХБ 2016b, Хавсралт II, догол мөр 3)

³⁶ Засгийн газрын бус зэвсэгт бүлэглэл, хамгаалалтын хүчинд шууд ба шууд бус дэмжлэг үзүүлэх талаар (ЭЗХАХБ 2016b, Хавсралт II, догол мөр 3)

³⁷ Засгийн газрын болон хувийн хамгаалалтын хүчний эрсдэлийн менежмент (ЭЗХАХБ 2016b, Хавсралт II, догол мөр 10)

Амьдрах орчин гэдэг нь амьд организм болон тэдгээрийн амьгүй орчинтой харилцах нөхцөлийг дэмжсэн газрын гадаргуу, цэвэр ус, далай тэнгисийн газарзүйн нэгж юм.

Эх үүсвэр: (ДДБОС 2018)

Уугуул иргэд гэдэг нь нийгэм, соёлын ялгаатай бүлэгт хамрагдах хүмүүс юм. Тэднийг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд: (i) өөрийгөө нийгэм, соёлын ялгаатай бүлэгт хамрагддаг гэж тодорхойлсон бөгөөд бусдаар хүлээн зөвшөөрөгдсөн; (ii) газар зүйн байршлын хувьд өвөг дээдсийн амьдарч байсан газар нутагт амьдардаг, тодорхой газар нутаг, ажил, болон байгалийн баялгийг улирлын чанартай ашигладаг бүлэг; (iii) ёс заншил, эдийн засаг, нийгэм болон улс төрийн институцийн хувьд нийтээс ялгаатай, тусдаа бүлэг; болон (iv) амьдарч байгаа улс, бүсийн албан ёсны хэлнээс ялгаатай хэл, авиаг хэрэглэдэг бүлэг гэх мэт. Ингэж тодорхойлоход зарим шинж чанар маш бага байх, эсвэл бүр устаж алга болсон байж болох ч энэ нь байсан бөгөөд уугуул иргэдийг тодорхойлоход чухал ач холбогдолтой гэдгийг анхаарах нь чухал юм.

Эх үүсвэр: (ДДБОС 2018)

Албадан нүүлгэх гэдэг Газар эзэмшил эсвэл Газар ашиглалтын хоригийг эсэргүйцэх эрхгүйн улмаас түр болон удаан хугацаагаар биет болон эдийн засгийн хувьд өөр нутаг дэвсгэрт нүүлгэн шилжүүлэхийг хэлнэ.

Эх үүсвэр: (НҮББОХ 2018)

Хуульчлах гэдэг нь үндэсний хууль журмын дагуу шаардлагатай тусгай эрх, лицензийг бичил уурхай эрхлэгчид авах боломжийг бүрдүүлэх процесс юм.

Эх үүсвэр: (UNITAR & UN Environment 2018)

Ажил хэрэгч зөвлөгөөн гэдэг нь хоёр талт процесс юм: Үүнийг (a) төсөл хөтөлбөрийн төлөвлөлт хийгдэж байх үед эхэлж нөхцөл байдлын талаар шаардлагатай мэдээлэл цуглуулж төслийн саналд тусгах; (b) хамтрагч талуудын санал, зөвлөгөөнд чухал ач холбогдол өгч, ялангуяа байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөг тодорхойлох, түүнийг бууруулах стратеги боловсруулахад хамтрагч талуудын саналыг авч тусгахад; (c) байгаль орчин, нийгмийн чиглэлийн эрсдэл байнга гарч байдаг учраас зөвлөгөөнийг тогтмол хийдэг; (d) урьдчилан цуглуулж хүргэсэн ач холбогдолтой, ил тод, бодит, утга төгөлдөр, хүртээмжтэй мэдээлэлд суурилан хамтрагч талуудын хэл соёл, зан заншилд тохирсон, ойлгомжтой байдлаар зөвлөлдөх боломж бүрдүүлэх; (e) санал, зөвлөмж, мэдээлэлд анхаарал хандуулж хариу өгөх; (f) төсөлд хамрагдагч талуудын идэвх санаачилгатай, бүтээлч оролцоог дэмжих; (g) гадны булхай, арга заль, саад тотгор, дарамт шахалт, ялгаварлан гадуурхалт, айлган длэлтээс ангид байх боломж бүрдүүлэх; болон (h) хэрэгжүүлэгч агентлаг баримтжуулж, тодруулах зорилгоор хийдэг.

Эх үүсвэр: (ДДБОС 2018)

Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц хүний эрүүл мэндийг мөнгөн усны хордлогоос хамгаалах зорилготой Минаматагийн конвенц 2017 оны 8 дугар сард хүчин батлагдсан. Конвенцын хүрээнд хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны хаягдлыг хянаж зохицуулах, багасгах, халах зорилготой юм.

Эх үүсвэр: (mercuryconvention.org)

Үе шаттайгаар сөрөг нөлөөллийг бууруулах гэдэг нь биологийн төрөл зүйлд учруулах сөрөг нөлөөллийг багасгах, зайлсхийх, нөхөн сэргээх замаар байгаль орчныг хамгаалах, доройтлыг багасгахад чиглэсэн эрэмбэлсэн арга хэмжээг хэлнэ. Зайлсхийх, бууруулах, болон нөхөн сэргээх эдгээр арга хэмжээнүүд хийгдсэний дараа үлдэгдэл нөлөөлөл байгаа нөхцөлд биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалдаг.

Эх үүсвэр: (IFC Performance Standard 6); and ([Webpage The Mitigation Hierarchy: No net loss and net positive impact](#))

Мөнгө угаах гэдэг нь хууль бусаар олсон мөнгөний гарал үүслийг өөрчлөх зорилгоор хийсэн эрүүгийн гэмт хэрэг юм. Энэ нь тухайн мөнгөний эх үүсвэрийг мэдэгдүүлэлгүйгээр ашиглах боломжийг мөнгө угаагчид олгодог процесс юм. Хууль бус зэвсэг худалдах, хууль бусаар хил нэвтрүүлэх/контрабанд, мансууруулах бодис зөөх болон биеэ үнэлэх сүлжээ гэх мэт зохион байгуулалттай гэмт хэргээс маш их хэмжээний мөнгө угаах асуудал гардаг. Мөн түүнчлэн хууль бусаар мөнгө олох, хууль бус худалдаа наймаа, авилга хээл хахууль, цахим луйвар зэргээс маш их мөнгө олж болдог бөгөөд энэ мэт буруу замаар олсон мөнгөний эх үүсвэрийг нууцлахын тулд мөнгө угаах шаардлага гардаг. Гэмт үйлдлээс их хэмжээний орлого олсон тохиолдолд үүнийг хийсэн этгээд эсвэл бүлэг этгээд хийсэн үйлдэл болон холбогдох хүмүүсийн анхаарлыг татахгүйгээр энэхүү хөрөнгө мөнгийг ашиглах арга олох хэрэгтэй болдог. Үүнийг тухайн хөрөнгийн эх үүсвэрийг өөрчлөх, өөр зүйлд хувиргах болон үүнд анхаарал бага хандуулдаг өөр газарт аваачих зэрэг гэмт үйлдлийг хийдэг байна.

Эх үүсвэр: (FATF 2019) ([Цахим хуудас: Мөнгө угаах](#))

Засгийн газрын бус зэвсэгт бүлэглэл гэдэг нь улс төр, үзэл суртал, эдийн засгийн эрх мэдэл олж авах зорилгоор зэвсэг ашиглаж болзошгүй бүлэг этгээдийг хэлнэ. Тэд засгийн газрын зэвсэгт хүчний бүтэц, засгийн газар хоорондын хамтын ажиллагааны бүтцэд багтдаггүй. Тэд оршин байгаа улсынхаа засгийн газрын удирдлагад байдаггүй бөгөөд өөрсдийн сүлжээний удирдлага дор ажилладаг.

Эх үүсвэр: (CRAFT 2018)

ЭЗХАХБ-ын зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрээс гаралтай эрдэс баялгийн хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний магадлан шинжилгээний удирдамж нь хүний эрхийг хүндэтгэх, ашигт малтмал ашиглах явцдаа зөрчилдөөнийг хурцадмал байдалд оруулахаас зайлсхийхэд нь компаниудад туслалцаа дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Мөн түүнчлэн энэхүү удирдамж нь ил тод нийлүүлэлтийн сүлжээ бүрдүүлэх, нийлүүлэлтийн сүлжээнд оролцогчдын дунд үр дүнтэй харилцаа тогтоох таатай нөхцөлийг бүрдүүлснээр улс орнууд байгалийн баялгаасаа ашиг шим хүртэх боломжтой болж ашигт малтмал нь зөрчил мөргөлдөөн, хүний эрхийн зөрчил, аюултай байдлын шалтгаан болохоос сэргийлэхэд хувь нэмэр оруулна.

Эх үүсвэр: (CRAFT 2018)

ЭЗХАХБ-ын зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрээс гаралтай эрдэс баялгийн хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний магадлан шинжилгээний удирдамжийн Хавсралт II-д тусгасан эрсдэлүүд нь ашигт малтмалын хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээ хүлээн зөвшөөрдөггүй хүний эрхийн ноцтой зөрчил болон зөрчил мөргөлдөөнүүд орсон. Эдгээр эрсдэлүүд нь зөрчил мөргөлдөөн, өндөр эрсдэлтэй нутаг дэвсгэрээс гаралтай эрдэс баялгийн олборлолт, баяжуулалт, худалдаа, экспортын үйл ажиллагаатай холбоотой үүсдэг бөгөөд маш их хор нөлөөтэй юм.

Эх үүсвэр: (CRAFT 2018)

Биет нүүлгэн шилжүүлэлт гэдэг нь түр болон удаан хугацаагаар иргэдийг нүүлгэн суурьшуулах, мөн иргэд оршин суух газар болон орон гэрээ алдахыг хэлнэ.

Эх үүсвэр: (ДДБОС 2018)

Бохирдол гэдэг нь хатуу, шингэн, хий хэлбэрт хуримтлагдсан хортой болон хоргүй химийн нэгдэл/бохирдуулагч юм; мөн түүнчлэн халуун хаягдлыг усанд алдах, урт болон богино хугацааны уур амьсгалын өөрчлөлт, үнэр, дуу чимээ, чичиргээ, цацраг, цахилгаан соронзон энерги, хүний хараанд нөлөө үзүүлэхүйц гэрэл зэрэг нь бохирдуулагчид орно.

Эх үүсвэр: (ДДБОС 2018)

Хамгаалалтын бүс нутаг гэдэг нь байгалийн унаган төрх, соёлын үнэт зүйлийг удаан хугацаанд хэвээр нь хадгалах зорилгоор холбогдох хууль журмын дагуу хамгаалалтад авсан бүс нутгийг хэлнэ. Хамгаалалтад авсан бүс нутгийн хил хязгаарыг тогтоож нөхөн сэргээх, сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.

Эх үүсвэр: (CRAFT 2018)

Хаягдал гэдэг нь ашигт малтмал баяжуулах процессоос гарсан эдийн засгийн ач холбогдолгүй агуулга бүхий завсрын болон эцсийн бүтээгдэхүүн юм. Баяжуулалтын хаягдлыг хаягдлын санд хуримтлуулдаг бөгөөд үүнд агуулагдаж байгаа алтыг ялгах зорилгоор дахин баяжуулдаг.

Эх үүсвэр: (CRAFT 2018)

Терроризмыг санхүүжүүлэх гэдэг нь террорист хөдөлгөөн, террористууд болон террорист байгууллагуудыг санхүүжүүлэхийг хэлнэ.

Эх үүсвэр: ([Терроризм болон үүнийг өргөжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийн талаарх нэр томъёоны тайлбар толь](#))

Эрүүдэн шүүх гэдэг нь тухайн хүнээс болон хөндлөнгийн этгээдээс тодорхой мэдээлэл авах, хийсэн хэргийг нь хүлээлгэх, тухайн хүн болон хөндлөнгийн этгээдийн хийсэн болон хийсэн гэж сэжиглэгдэж байгаа үйлдлийн төлөө шийтгэх, тухайн хүнийг болон хөндлөнгийн этгээдийг айлган сүрдүүлэх зорилгоор болон ялгаварлан гадуурхах бүх шалтгаанаар санаатайгаар бие махбод, сэтгэл санааны өвдөлт өгөх, зовоох үйлдлийг хэлнэ. Үүнд хуулийн дагуу оноосон шийтгэлээс үүсэх өвдөлт, зовлон орохгүй.

Эх үүсвэр: (CRAFT 2018); (ОНСНР 1984); (Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг НҮБ-ийн конвенц)

Эмзэг бүлэг гэдэг нь нийгэм эдийн засгийн нөхцөл, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, яс үндэс болон тухайн хүний баялгаас хүртэх болон хөгжих боломжид нөлөөлөх бусад шалтгаанаар эмзэг болсон бүлгийг хэлнэ. Энэ бүлэгт өрх толгойлсон эмэгтэй эсвэл хүүхдийн гэр бүл, нэн ядуу иргэд, өндөр настан, эрсдэлтэй хүүхэд, залуучууд, халагдсан дайчид, шахагдан гадуурхагдсан хүмүүс, буцаж ирсэн дүрвэгчид, ДОХ-ын халдвар авсан хувь хүн, гэр бүл, шашны болон үндэсний цөөнх, дүрвэж ирсэн ажилчид, нутгийн уугуул иргэд, цөөнх, зарим нийгэмлэг болон эмэгтэйчүүд гэх мэт нийгэм эдийн засгийн ялгаварлан гадуурхалтын хохирогчид ордог.

Эх үүсвэр: (RJC 2019) & (IRMA 2019)

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенцоор тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхдийг худалдаалах, өрийн барьцаанд өгөх, боолчлох, албадан хөдөлмөр эрхлүүлэх, зэвсэгт мөргөлдөөнд дайчлах, хүчээр элсүүлэх зэрэг боолчлолын бүх хэлбэрүүд, түүнтэй төстэй аргууд;
- Хүүхдийн биеийг үнэлүүлэх, садар самуун агуулга бүхий материал үйлдвэрлэх, садар самууны үзвэр, үйлчилгээнд ашиглах, татан оролцуулах, уг ажлыг санал болгох;
- Холбогдох олон улсын гэрээнд заасанчлан мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамнуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, эсвэл санал болгох;
- Үйл ажиллагааны мөн чанар, үр дагаврын хувьд хүүхдийн эрүүл мэнд аюулгүй байдал, зан суртахуунд **аюул учруулахуйц ажлууд** орно.

Эх үүсвэр: (Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ Конвенц C182)



planet**GOLD**

Making a world of difference
in small-scale gold mining.

A GEF Initiative



Санхүүжүүлэгч



Үндсэн хэрэгжүүлэгч



Хамтрагчид



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



planetgold.org